

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
АГЕНТЛАГ

**МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТ  
БОЛОН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУДАЛГАА**

**(ТАТВАР ХУРААЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ II ҮЕ  
ШАТ: ТАТВАР ТӨЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ  
БЭХЖҮҮЛЭХ НЬ)**

**ЭЦСИЙН ТАЙЛАН**

2003 оны 3 сар

**САНХҮҮ, ТӨСВИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН**

## Өмнөх үг

Япон улсын Засгийн газар нь Монгол улсын Засгийн газрын хүсэлтээр тус улсын татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх судалгааны ажлыг явуулахаар шийдвэрлэсний дагуу Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагаас Монголын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих судалгааны нэг хэсэг болгон уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг 2001 оны 12 сараас 2003 оны 2 сарын хооронд Санхүүгийн судалгааны институтын Кояанаги Юүжиро ахлагчтай судалгааны хэсгийг 7 удаа Монголд томилон ажиллууллаа. Мөн 2001 оны 11 сараас 2003 оны 3 сарын хооронд Хитоцүбаши Их сургуулийн профессор Асанүма Шинжигээр ахлуулсан хяналтын зөвлөлийг байгуулан тус судалгааны ажилд мэргэжлийн болоод арга зүйн талаас нь хяналт тавьж ажиллалаа.

Судалгааны хэсэг нь Монгол улсын Засгийн газар болон Үндэсний Татварын Ерөнхий газрын холбогдох хүмүүстэй санал солилцон, татвар хураалт болон хяналтын ажил хариуцсан татварын ажилтнуудад зориулсан сургалт семинаруудыг зохион байгуулсны зэрэгцээ, өөрийн оронд хийхээр төлөвлөгдсөн судалгаа шинжилгээний ажлуудаа дуусгасны үндсэн дээр энэхүү тайланг боловсрууллаа.

Энэхүү тайлан нь Монгол улсад татварын эрх тэгш, зохистой тогтолцоог бүрдүүлэх болон татварын тогтвортой орлогыг хангахад хувь нэмэр болохын хамт манай хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд нэг алхам болно гэж найдаж байна.

Эцэст нь судалгааны ажилд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлсэн бүх хүмүүст чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

2003 оны 3 сар

-----  
Японы Олон Улсын Хамтын  
Ажиллагааны Агентлагийн  
Ерөнхийлөгч  
Такааки Каваками

## Илгээлт

Японы Олон Улсын Хамтын  
Ажиллагааны Агентлагийн Ерөнхийлөгч  
Такааки Каваками Танаа

Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих судалгааны хүрээнд хийгдэж буй татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх судалгааны ажлын II шат болох Татвар төлөгчийн талаарх мэдээллийн хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх нь сэдэвт судалгааны тайланг өргөн барьж байна.

Уг судалгааны ажлын хүрээнд судалгааны хэсэг 2001 оны 11 сараас 2003 оны 2 сар хүртэлх хугацаанд 7 удаа Монгол улсад очиж газар дээрх судалгаа явууллаа. Монгол улсад хийсэн судалгааны ажил болон Японд хийж гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнгийн талаар Монгол улсын Засгийн газар болон Үндэсний Татварын Ерөнхий газар, бусад холбогдох байгууллагуудтай зөвлөлдөн санал солилцсоны дүнд Монгол улсын татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааны хэсэг нь татвар төлөгчдийн талаарх мэдээллийн системийг бүрдүүлэх, татвар хураалт хариуцсан байцаагчдад зориулсан сургалт семинар, хяналт шалгалтын байцаагчдад зориулсан хяналт шалгалтын гарын авлага зэрэг арга зүйн зааварчилгаа зөвлөмжүүдийг хийсний үндсэн дээр уг тайланг боловсрууллаа.

Судалгааны хэсгээс Монгол улсын татварын тогтолцоог бэхжүүлэх нь Монгол улсын цаашдын хөгжилд зайлшгүй шаардлагатай зүйл хэмээн үзсэний үндсэн дээр Монгол улсын Засгийн газарт энэ чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгөхийг санал болголоо.

Судалгааны ажлыг явуулахад хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэн, Монголд байх хугацаанд халуун дотноор хүлээн авсан Монгол улсын Засгийн газар, Үндэсний Татварын Ерөнхий газар болон холбогдох бусад газруудад чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг болон түүний Монгол дахь төлөөлөгчийн газар, Гадаад Явдлын Яаманд үнэтэй санал зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлсэнд гүн талархал илэрхийлье.

2003 оны 3 сар

Монгол улсын зах зээлийн эдийн засагт  
шилжих шилжилтийг дэмжих судалгааны  
хэсгийн ахлагч Кояанаги Юүжиро

# ГАРЧИГ

## ТОВЧ АГУУЛГА (Executive Summary)

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Татварын хяналт шалгалтанд ач холбогдол

#### бүхий хөндлөнгийн мэдээллийг цуглуулах болон ашиглах

1.1 Татварын хяналт шалгалтан дахь баримт мэдээллийн ач холбогдол	15
1.2 Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба түүнийг цуглуулах арга	15
1.3 Хөндлөнгийн мэдээлэл цуглуулах нэмэлт арга болон ашиглах арга	20

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. Татвар төлөгчийн дугаараар татвар төлөгчийг хянах хяналтын өнөөгийн байдал болон тавигдаж буй асуудлууд

2.1 Татвар төлөгчийг хянах хэрэгцээ, шаардлага	27
2.2 Монгол улс дахь татвар төлөгчийн хяналтын өнөөгийн байдал	27
2.3 Татвар төлөгчийн дугаарыг шалгах	27
2.4 Татвар төлөгчийн бүртгэл болон дугаар	29
2.5 Татвар үл тайлагнагчийг илрүүлэхэд гардаг бэрхшээлүүд ба түүнийг шийдвэрлэх арга зам	31

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн систем

3.1 Татвар төлөгчийн талаарх мэдээ материалыг цахимжуулахын ач холбогдол, татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн талаар	34
3.2 Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагаа болон бүтэц	39
3.3 Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдах, ажиллуулах	43
3.4 Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх систем	49
3.5 Цаашид татвар төлөгчийн талаарх баримт мэдээллийг цахимжуулахтай холбогдуулан шийдвэрлэвэл зохих асуудал	50

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Гаалийн тогтолцоо

4.1 Гаалийн байгууллагын үйл ажиллагаа	52
4.2 Хилийн гаалийн байдал	60
4.3 Гаалийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлт	72
4.4 Цаашид шийдвэрлэвэл зохих асуудал	78

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ҮТЕГ-ийн татварын ажилтны сургалт**

5.1	ҮТЕГ-ийн сургалтын түүхэн үүсэл хөгжил ба өнөөгийн байдал.....	81
5.2	Татварын байцаагч нарт зориулсан шаталсан сургалтын чиг хандлага, үнэлгээ.....	82
5.3	Татвар төлөгчдөд зориулсан сургалт, үйлчилгээ.....	87
5.4	Татварын ажилтны сургалтын төслийн санал.....	88

## **List of Table**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

Хүснэгт 1-1	Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба цуглуулах ажлыг хариуцсан ажилтан (Компьютераар боловсруулах мэдээлэл)	16
Хүснэгт 1-2	Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба цуглуулах ажлыг хариуцсан ажилтан (Цаасан мэдээлэл)	18

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

Зураг 1	Хөндлөнгийн мэдээллийн сангийн ерөнхий схем	35
Хүснэгт 1	Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санд агуулагдах мэдээллүүд	40
Зураг 2	Мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагааны бүтэц	40
Хүснэгт 2	Системийн сүлжээний бүтэц	41
Зураг 3	Мэдээллийг оруулах үед тулган шалгах ерөнхий урсгал	44
Зураг 4	Системийн меню-г схемээр үзүүлсэн байдал	45
Зураг 5	Гаалийн мэдээг дэлгэцэнд үзүүлсэн байдал	46
Зураг 6	Мэдээллийг хэвлэн гаргах байдал	47
Зураг 7	ГЕГ-аас мэдээлэл импортлоход гарах дэлгэц	48

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

Зураг 4-1	Улсын татварын орлого дахь гаалийн орлогын үзүүлэлт	52
Хүснэгт 4-2	Гаалийн орлогын дэлгэрэнгүй, нийт татвартай харьцуулсан нь	52
Зураг 4-3	Нисэхийн гаалийн хилээр нэвтэрсэн импортын бүтэц (2001он)	53
Зураг 4-4	Импортлогч орнуудын гадаад худалдаанд эзлэх хувь, өөрчлөлт	55
Зураг 4-5	Гаалийн хилээр нэвтрэх импортын барааны урсгал	56
Зураг 4-6	Монгол улсын олон улсын ачаа барааны гол урсгал	61
Хүснэгт 4-7	Ачааны урсгал/ ачаа тээвэрлэлтийн ялгаатай байдал	61
Зураг 4-8	БНХАУ-Монгол улсын хилийг нэвтрэх байдал	62
Зураг 4-9	Замын –Үүдээр нэвтэрсэн барааны үнийн дүн (сая төгрөг)	63
Хүснэгт 4-10	Гаалийн зуучлалын үйлчилгээний хэлбэрийн давуу болон дутагдалтай тал	74
Зураг 4-11	Риск менежмент нэвтрүүлэхийн үр ашиг	76

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

Хүснэгт 5-1	2001-2004 ҮТЕГ-ын сургалтын төлөвлөгөө	83
Хүснэгт 5-2	Татварын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт	85
Хүснэгт 5-3	Татвар хураалтын стратеги	86
Хүснэгт 5-4	Татварын хяналт шалгалт	86

## **ТОВЧИЛСОН ҮГ**

ҮТЕГ	Үндэсний Татварын Ерөнхий Газар
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ЖАИКА (JICA)	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ААНБОАТ	Аж Ахуйн Нэгж Байгууллагын Орлогын Албан Татвар
ИОТТХ	Иргэний Орлого Тодорхойлох Хуудас
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ХХААЯ	Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
ИБМҮТ	Иргэний Бүртгэл Мэдээллийн Үндэсний Төв
АМХЭГ	Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар
ЗЦГ	Замын Цагдаагийн Газар
ҮХХБГ	Үл Хөдлөх Хөрөнгийн Бүртгэлийн Газар

## **Эцсийн тайлангийн товч агуулга**

### **1. «Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийг цуглуулж ашиглах нь» тайлангийн товч агуулга**

Тус судалгааны хэсгээс урьд нь гаргасан «Хөндлөнгийн мэдээллийг цуглуулж ашиглах талаархи гарын авлага (төсөл)»-д үндэслэн, ҮТЕГ-аас 2002 оны 9 сарын 12-ны өдрийн ҮТЕГ-ын даргын 171 тоот тушаалаар «Татвар төлөгчийн холбогдолтой хөндлөнгийн мэдээллийг цуглуулах ба татварын хяналт шалгалтанд ашиглах журам» гарсан билээ. Тус журмаас үзэхэд татварын хяналт шалгалтанд ашиглагдах хөндлөнгийн мэдээллийг ① Захиргааны байгууллагаас ирэх мэдээлэл, ② Иргэн ба аж ахуйн нэгж байгууллагаас ирэх мэдээлэл, ③ Татварын албаны дотоод мэдээллээс авах мэдээлэл, ④ Сонин хэвлэл, радио телевиз гэх мэт мэдээллийн хэрэгслээс авах мэдээлэл гэсэн 4 хэсэгт хувааж, мэдээлэл тус бүрийн төрөл, авах эх үүсвэр, цуглуулах арга, цуглуулах ажлыг хариуцагч болон цуглуулах хугацааг түүнд зааж өгчээ.

Хөндлөнгийн мэдээллийн баазыг байгуулж, компьютерээр цуглуулж, ашиглах мэдээлэлд «Гаалийн мэдээ», «НӨТ-ын падаан», «Спирт хуваарилалт, борлуулалтын мэдээ», «Аж ахуйн нэгжийн суутган татварын тайлан ТТ-11(2), (3)», «Хөндлөнгийн мэдээллийн хуудас»-ыг оруулсан. Эдгээр мэдээллийг бүгдийг ҮТЕГ-ын мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс дээр төвлөрүүлэн компьютерт оруулж, графикаар татварын албадад хүргүүлж, татварын хяналт шалгалтанд ашиглах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Бусад мэдээллийн хувьд цаасаар цуглуулж ашиглах юм.

Тиймээс энэхүү тайланд дээрх мэдээллүүд дотроос чухал шинжтэй мэдээллийг татварын хяналт шалгалтанд ашиглах үед анхаарах зүйлийг зааж, хяналт шалгалтын байцаагч нар ашиглах боломжтой болгосон. Мэдээлэл хянах гэх мэт процедурын шинжтэй ажлын талаар дээрх гарын авлага (санал)-д дурдсан.

### **2. «Татвар төлөгчийн дугаараар татвар төлөгчид хяналт тавьж буй өнөөгийн байдал ба шийдвэрлүүштэй асуудлууд»-ын товч агуулга**

Татварыг үнэн зөв, тэгш шударга ногдуулахын тулд татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжид тавих хяналт сайн явагдах явдал чухал нөхцөл юм. Татвар төлөгчийн хяналт сайн байна гэдэг нь татварын албадын харъяалах бүх татвар төлөгчийг тодорхойлж чадах явдал юм. Өөрөөр хэлбэл, татварын албадад татвар төлөгч давхардах, эсхүл орхигдох явдал байхгүй болно гэсэн үг.

ҮТЕГ-т 2002 оны 1 сараас орчин үеийн татварын мэдээллийн систем болох ORACLE-ыг нэвтрүүлснээр татварын албад дахь татвар төлөгчийн мэдээллийн баазад татвар төлөгч бүрийн дугаар бүртгэгдэхийн хамт ҮТЕГ дахь татвар төлөгчийн төв мэдээллийн баазад ч мөн ижил дугаар бүртгэгдэн, татварын албад дахь нийт татвар төлөгчдийг нэгдсэн нэг төвөөс хянах нөхцөл бүрдсэн юм. Мэдээж, татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дугаар давхардахгүй байх арга энд хэрэглэгдсэн бөгөөд татвар төлөгчийн дугаараар хөөж татвар төлөгчид хяналт тавих нь системийн хувьд зүй зохистой юм. Иргэний хувьд иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс төрөх үед олгогддог 10 оронтой иргэний бүртгэлийн дугаар нь татвар төлөгчийн дугаарт ашиглагддаг (Үүний талаар тайланг харна уу). Аж ахуйн нэгж, байгууллагын хувьд улсын бүртгэлийн албанаас аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл авах үед ҮТЕГ-аас урьдчилан бэлдсэн 7 оронтой улсын бүртгэлийн дугаар олгогддог ба энэ нь аж ахуйн нэгжийн татвар төлөгчийн дугаар болдог.


Эцэст нь татвар төлөгчид тавих хяналттай холбогдуулан хэлэхэд татвар төлөгчийн оршин суугаа газар өөрчлөгдөх үед үүсэх хаягийн өөрчлөлтөө мэдүүлээгүй этгээдийг илрүүлэхтэй холбогдсон асуудал ба түүнийг шийдвэрлэх арга хэмжээний талаар санал зөвлөмж гаргасан болно.



### 3. Хөндлөнгийн мэдээллийн сангийн систем

- (1) Татвар төлөгчийн талаарх мэдээ материалыг цахимжуулахын ач холбогдол, татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн талаар

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн ерөнхий схемийг Зураг.1-д үзүүлэв.



**Зураг. 1 Хөндлөнгийн мэдээллийн сангийн ерөнхий схем**

Уг төслийн хүрээнд татвар төлөгчийн талаарх мэдээ материалыг цахимжуулах ажлыг дэмжнээр татвар хураалтын тогтолцоо бэхжихэд зохих үүрэг гүйцэтгэх бөгөөд доор дурьдснаар

- Татвар төлөгчийн тайлангийн үнэн зөв байдлыг татварын баримт материалтай тулган шалгаж магадлах
- Татварын хяналт шалгалтын мэдээллийг хангалттай бүрдүүлснээр хяналт шалгалтын ажлын үр бүтээлийг дээшлүүлэх
- Татварын баримт материалыг хангалттай бүрдүүлснээр татварын бодлогыг тодорхойлох

ач холбогдолтой.

Иймд уг төслийн хүрээнд хөндлөнгийн этгээдээс олж болох татвар төлөгчийн талаарх мэдээ материалаар мэдээллийн сан үүсгэх ажлыг хийж гүйцэтгэв. Энэхүү мэдээллийн сан нь 1) Хөндлөнгийн этгээдийн бичиж үйлдсэн татвар төлөгчийн талаарх мэдээллээр мэдээллийн сан үүсгэх, 2) Клиент сервэр горимтой системийг үүсгэх, 3) Алслагдсан газрууд алсын сүлжээгээр дамжуулан мэдээллийг хамтран эзэмших, 4) Мэдээлэл ашиглалтын байдлыг мэдэх болон хамгаалалтын арга хэмжээ авах гол онцлогтой.

- (2) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагаа болон бүтэц

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сан нь 1) Татвар төлөгчийн дугаарыг түлхүүр болгон татвар төлөгчийн талаарх мэдээлэлтэй тулган шалгах, 2) Шаардлагын дагуу боловсруулах мэдээллийг хайх, 3) Байгууллагын дотоодын тайлан мэдээнд зориулсан мэдээллийн нэгтгэлийг гаргах функцээс гадна 4) Мэдээлэл солилцох, 5) Мэдээллийн ашиглалтыг хянах, 6) Хамгаалалтын зэрэг функцтэй.

Уг мэдээллийн санд гаалийн мэдээ, хөндлөнгийн мэдээлэл цуглуулах хуудас, спиртийн мэдээ багтах бөгөөд мөн цугларах боломж нь бүрдсэн тохиолдолд НӨАТ-ын падаан, суутган авсан татварын тайланг ч багтаах болно.

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн бүтэц нь компьютерээс бүрдэх клиент сервэр горимын систем бөгөөд OS-д MS-Windows 2000 Server-г, DBMS-д Oracle 9-г ашигласан.

- (3) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдах, ажиллуулах

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн хүрээнд мэдээллийн болон хэрэглэгчдийн мэдээлэл ашиглалтын байдлыг ҮТЕГ-ын Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс хянах юм. Мэдээллийн санд агуулагдах мэдээллийн хувьд, ГЕГ-аас алсын сүлжээ (WAN)-гээр дамжуулан мэдээлэл авах ба бусад мэдээллийн хувьд мэдээллийг цаасаар цуглуулан авч, гараар шивж компьютерт оруулна. Агуулагдсан мэдээллийн байнгын хэвийн байдлыг зохих ёсоор хангана. Мэдээллийг анх системд хүлээж авахдаа болон татвар төлөгчийн талаарх мэдээллийг харъяалуулах үед тулган шалгах үйлдлийг хийж гүйцэтгэх ба татвар төлөгчийн дугаарыг түлхүүр болгон мэдээлэл тус бүрийг татвар төлөгчийн талаарх үндсэн мэдээлэл нэг бүртэй тулган шалгана.

Мэдээллийн санд агуулагдаж буй мэдээллийг оператороор дамжуулан ҮТЕГ-т болон татварын албадад авч ашиглана. 7 жил агуулсан мэдээллийг устгана. Мөн мэдээлэл ашиглалттай холбоотой мэдээллийг систем өөрөө автоматаар бүртгэнэ. Мэдээллийн сан дотор мэдээлэл ашиглалтын байдлыг хянах функц суулгахаас гадна OS-н ашиглалтын архивчилсан бүртгэлийг хянах зэргээр мэдээллийн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөн back-up буюу нөөц хадгалалтыг тогтмол хугацаанд хийх ба үүнд багтаамж ихтэй хадгалах хэрэгслийг ашиглана. Эдгээрээс гадна цахилгаан тасрахад авах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, системийн өрөөнд орж гарах хүмүүст хяналт тавих зэрэг ажлууд хийгдэнэ.

- (4) Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) систем

Уг төслийн хүрээнд ҮТЕГ-ын хяналтанд байдаг татвар төлөгчийн талаарх үндсэн мэдээллийг ГЕГ руу илгээх системийг байгуулав. ҮТЕГ татвар төлөгчийн талаарх үндсэн мэдээллээр тогтмол хугацаанд файл үүсгэж, түүнийгээ ГЕГ-тай мэдээлэл солилцох фолдерт хадгална. ГЕГ тэрхүү фолдерт хандаж алсын сүлжээ (WAN)-гээр дамжуулан файлыг хуулбарлаж авах юм.

- (5) Татвар төлөгчийн талаарх баримт мэдээллийг цахимжуулахтай холбогдуулан цаашид шийдвэрлэвэл зохих асуудал

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн хувьд нэг мэдээллээс нөгөө мэдээллийн хооронд «хөндлөн чиглэлийн» хайлт хийх боломжтой функц хийх, мэдээллийн агуулга, хэмжээг өргөжүүлэх, мэдээллийг системд агуулах үр бүтээмжтэй арга замыг бий болгох зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) системийн хувьд, илгээсэн татвар төлөгчийн талаарх үндсэн мэдээллийг гаалийн байгууллагад үр ашигтай ашиглаж болохуйц системийг үүсгэн байгуулах болон зарим зүйлийг засварлан өөрчлөх шаардлагатай байгаа юм.

Татвар төлөгчийн талаарх мэдээллийн сангийн хувьд, одоо ашиглагдаж буй татвар төлөгчийн мэдүүлгээр үүсгэгдсэн мэдээллийн сан болон хөндлөнгийн мэдээллийн санг хооронд нь уялдуулан нэгтгэж, иж бүрэн байдлаар ашиглаж болох орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

#### 4. Гаалийн тогтолцоо

Монгол улсын эдийн засагт гаалийн байгууллага ихээхэн ач холбогдолтой. Гааль нь экспорт импортын бараанд гаалийн татвар, НӨАТ болон онцгой албан татвар ногдуулдаг ба 2001 оны улсын татварын орлогод эзлэх гаалийн татварын орлого 40 хувиас илүү байна. 1999 оны статистик мэдээнээс үзвэл, улсын нийт НӨАТ-ын орлогын 54 хувийг гаалийн байгууллагын бүрдүүлэлт эзэлж, татварын байгууллагаас илүү их хувь гаалийн байгууллагад ногдож байна. Энэ нь улсын татварын байгууллагын НӨАТ-ын орлогын бүрдүүлэлт сул байгааг илтгэнэ. Өнгөрсөн 10 жилд гаалийн байгууллагын үүрэг, улсын татварын системд эзлэх хувь эрс өссөн байна. Ингэж гаалийн байгууллагын татвар бүрдүүлэх үүргийг чухалчлан үзснээс болоод, гаалийн байгууллагын нөгөө нэг үүрэг болох “түргэн шуурхай үйлчлэхэд” нь саад бэрхшээл учирч буй гэж үзэж болно.

Гаалийн байгууллагын уг үндсэн үүрэг нь

1. Экспорт, импортын гаалийн бүрдүүлэлтийг түргэн шуурхай явуулах

2. Зүй зохистой татвар хураах гэсэн хоёр талтай шаардлагыг биелүүлэх явдал юм. Харин татвар хураалт нь бэхжээгүй Монгол орны хувьд 2-д дурдсан тал дээр ихээхэн хүч зарцуулж байгаа нь бодитой үнэн билээ. Гаалийн татвар бүрдүүлэлт улсын татварын орлогын 40 хувийг эзэлдэг гэдэг нь бусад оронтой харьцуулахад ангид жишээ болох бөгөөд татвар бүрдүүлэхийн төлөө түргэн шуурхай үйлчилгээг орхигдуулах энэ байдал цаашид үргэлжилбэл гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадахгүйд хүрэх юм (өнөө ч уул уурхайн салбарт иймэрхүү бодит жишээ гарч байна). Гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг дэлхий нийтийн стандарттай харьцуулахад онцын ялгаатай зүйл байхгүй, зүй ёсны чиг бодлого баримталж байгаа ч бодит үйл ажиллагаан дээр:

3. Бичиг баримтын шалгалтын явцад нэгж үнийн шалгалтыг хэтрүүлж хийн

4. Бүх бараанд үзлэг шалгалт зайлшгүй хийж байгаа нь уг бодлоготой нь үл нийцэх, чирэгдэл их, зардал өндөр үйл ажиллагаа юм. «Бүх мэдүүлэг хуурамч, алдаатай» гэсэн үзлийг урьтал болгон хяналт шалгалт явуулдаг учраас ((Монголын гаальд (буюу гаалийн байгууллагын удирдах түвшинд) Compliance-ийн (үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүлээн авах) талаар бодож үзэх явдал хангалтгүй байдаг)) ачаа барааг нэг бүрчлэн шалгах шаардлага тавигдаж, маш их цаг хугацаа заран, өндөр өртөг гаргаж байна.

Үүнийг шийдвэрлэхийн тулд найдвартай мэдүүлэгчид илүү таатай нөхцөл олгох (тухайлбал, гаалийн хилээр түргэн шуурхай нэвтрүүлэх) «урамшууллын систем» хэрэгтэй байна. Эдүгээ өндөр хөгжилтэй орнууд хууль дүрмийг дээдлэн сахих үүднээс «найдвартай мэдүүлэгчид тэр хэрээр нь хөнгөвчлөсөн үйлчилгээ үзүүлэх» нь зүйд нийцнэ гэж үзэж байгаа билээ. Ийм чиг бодлого баримтлах нь гааль болон түүгээр үйлчлүүлэгч аль алинд нь ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл:

- Гаалийн байгууллагын хувьд гүйцэтгэх ажлын хэмжээ багасах – ялангуяа, барааны үзлэг шалгалтанд шаардагдах хүн хүчний тоо буурна.
- Импортлогчийн хувьд гаалийн хилээр түргэн шуурхай нэвтрэх боломжтой болно.

Гаалийн байгууллага өнгөрсөн жилээс компьютерийн мэдүүлгийн систем хийж эхлэн, түүнийх нь үр дүн нүдэнд харагдахуйц болж ирсэн ба риск менежментийг нэвтрүүлэх учир холбогдол болон ухагдахууныг ойлгон ухамсарлах үндэс суурь тавигдсаар байна.

Одоогийн системд:

- Мэдүүлэг дэх үнийн дээд, доод хэмжээг автоматаар тооцоолон түүнд нь тохируулан үнэлэлт өгөх бүтэц зохион байгуулалт байхгүй
- Үүнтэй адилаар импорт, экспорт мэдүүлэгчдийн талаарх мэдээлэлдээ тулгуурлан найдвартай мэдүүлэгчийг ялгаж тогтоох бүтэц ч байхгүй

байдалтай байгаа ба дээрх зорилтыг биелүүлэхийн тулд мэдүүлэгчийн ажлын амжилт, барааны төрөл, бусад мэдүүлгийн агуулгын эрсдлийг тодорхойлох риск менежментийг цаашид гаалийн хилээр нэвтрүүлэх системд оруулах шаардлагатай.

Компьютерийн системийн цаашдын хөгжил нь дараахь үр ашгийг авчирна гэж үзэж болно. Үүнд:

- Хүний хүчин зүйл нөлөөлөх зүйл багасна(хээл хахууль буурах найдлагатай).
- Мэдүүлэг автоматаар хянаж шалгагдснаар, мэдүүлэгч, гаалийн ажилтан хоёр нүүр тулж

ажиллах боломж багасвал хууль бус үйлдэл гарах нөхцөл багасах нь зайлшгүй. Одоо ачаа барааны үзлэг шалгалтын үед мэдүүлэгч, гаалийн ажилтан нь хоёулхнаа байх тохиолдол их байна. Мөн ачаа бараа нь нүдний өмнө ил байгаа зэргээс хууль бус үйлдэл гарах нөхцөл боломж өндөр гэж үзэхээс өөр аргагүй. Ачаа барааны үзлэг шалгалт зайлшгүй хийх үүрэг үгүй болбол гаалийн байгууллага дахь хууль бус үйлдэл гарах нөхцөл багасна гэж найдаж болно.

- Бүрдүүлэлтийн дараахь шалгалтын хэрэгжилт (ҮТЕГ-аас авах мэдээний ашиглалт) Монголд бүрдүүлэлтийн дараахь шалгалтаар засаж залруулсан мэдүүлэг ердөө 1хувь хүрэхтэй үгүйтэй байна. Энэ шалгалтын тогтолцоог бүрэн хэрэгжүүлж чадвал гаалийн татвар хураалт нэмэгдэхийн зэрэгцээ гаалийн хилээр нэвтрэх үеийн үйлчилгээ ч түргэн шуурхай болно(Монголд бүрдүүлэлтийн дараахь шалгалт явуулахад хүндрэлтэй тул импортоор орж ирэх үед нь 100% татвар ногдуулах шаардлагатай болдог. Тийм учраас нарийн чанд үзлэг шалгалт хийх хэрэгтэй болон, цаг хүч зарцуулна. Хэрэв бүрдүүлэлтийн дараахь шалгалтын үүрэг нэмэгдвэл импортлох үеийн ажлын ачаалал багасах боломжтой). Үүний тулд импортлогчийн оршин буй хаягийг тодруулан мэдэх шаардлагатай. Одоо ҮТЕГ-тай сүлжээгээр холбогдон мэдээлэл солилцох болсноор импортлогчийн оршин буй хаягийг мэдэж чадах болно. ҮТЕГ нь хувь хүн импортлогчийн хувьд, найдвартай татвар төлөгчид л гадаад худалдаа эрхлэх зөвшөөрөл олгох арга хэмжээ авах гэж байгаа тул зөвшөөрлийн хугацааг шинэчлэх эсвэл тодорхой хугацаанд хаягийг шинэчлэн тогтоох зэрэг аргаар аль болох шинэ, үнэн бодит хаягийн мэдээллийг УГЕГ-т дамжуулах хэрэгтэй байна.

## **5. Татварын ажилтны сургалт**

### **5.1 TOR-ын ерөнхий агуулга**

Татварын ажилтны сургалтын өнөөгийн байдал болон тавигдаж буй асуудлуудыг үндэслэн TOR саналыг гаргасан. TOR нь (1) Татварын Ерөнхий Газрын татварын ажилтны сургалт (2) Татварын нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Энэ төслийн алс хэтийн гол зорилго нь зах зээлийн эдийн засгийн шилжилт, хөгжлийг дэмжих явдал юм. Татварын ажилтны сургалтын системийн шинэчлэлт болон зохион байгуулалтын талаар технологи шилжүүлснээр олон талтай эдийн засгийн болон худалдааны аливаа харилцаанд нийцэн ажиллах татварын ажилтны чадавхийг дээшлүүлэх, ингэснээр татвар хураалт, татварын орлого өсөх нэг нөхцөл болох ба цаашид өөрсдийн хүчээр сургалтын программ зохион ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Шинээр орсон ажилтанд төрийн албан хаагчийн ухамсрыг төлөвшүүлж, татварын ажилтан хүнд шаардлагатай мэдлэг, ур чадвар гэх мэт суурь шинжтэй зүйлсийг эзэмшүүлэх явдлыг зорилго болгосон «Анхан шатны курс», анхан шатны сургалтанд хамрагдсан ажилтнуудын дунд дотоод хяналт шалгалт, ажлын байдал зэргийг харгалзан шалгаруулах шалгалт хэрэгжүүлж, дунд албан тушаалтны ухамсар, чадварыг төлөвшүүлэх «Дунд шатны курс», улмаар дунд шатны курсэд хамрагдагсдаас тодорхой хугацаанд ажилласны дараа ажиллаж буй төлөв байдлыг харгалзан үзэж, сургалтанд хамруулж, ирээдүйд удирдах ажилтан болгох зорилготойгоор хэрэгжүүлэх «дээд шатны курс»-д хувааж, дээд шатны курсэд татварын онол, удирдлагатай холбоотой судалгаа явуулж, удирдах ажилтны мэдлэг, ур чадвар эзэмших явдлыг зорилго болгон, бодлого тодорхойлдог боловсон хүчин бэлтгэх тал дээр ажиллана. Мөн эдгээр сургалтын түвшинд таарсан сургалтын материал боловсруулж гаргана.

Дээрх ажлуудыг хэрэгжүүлэхийн тулд Монголын төрийн болон хувийн нэгжүүдийн татварын нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдах бөгөөд үүний тулд татварын болон нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийн түвшин тогтоох системийг бий болгон, хэрэгжүүлэхтэй холбогдох төлөвлөгөө болон арга замыг тодорхой болгоно.

### **5.2 Төслийн агуулга ба үр дүн**

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

(1) Татварын ажилтны сургалт

- a. Боловсон хүчний тогтолцоог бүрдүүлэх
- b. Орон нутгийн ажилтны сургалтын системийг боловсронгуй болгох
- c. Сургалтын хөтөлбөр боловсруулах
- d. Сурах бичиг болон сургалтын Video материал бэлтгэх
- e. Сургалт удирдах багш болон бодлого тодорхойлох түвшний боловсог хүчин бэлтгэх
- f. Сургалтын үр дүнг тодорхойлох
- g. Монголын татварын ажилтныг сургах сургалтыг Японд явуулах

(2) Татварын нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх

- Татварын нягтлан бодох бүртгэлийн талаарх сургалт болон өнөөгийн түвшин, тавигдаж буй асуудлуудад анализ хийх
- Мэргэжлийн зэрэглэл тогтоох зэрэг мэдлэгийн түвшин тогтоох системийг нэвтрүүлэх боломжийг судлах
- Системийг хэрэгжүүлэх, удирдах бүтцийн санал болон хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох
- Удирдах байгууллагын бизнес төлөвлөгөөг гаргах

(3) Дээрх судалгааны үр дүн

Судалгааг явуулснаар дараах үр дүнд хүрнэ гэж төлөвлөж байна.

- Татвар болон нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой сургалтын материалууд
- Татварын ажилтны сургалтын программ
- Сургалтын Video материалууд
- Татварын нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийн түвшин тогтоох системд зориулагдсан шалгалтын материалууд
- Татварын нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийн түвшин тогтоох системийг үүсгэн байгуулах
- Хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг гаргах

# **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

*ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТАНД АЧ ХОЛБОГДОЛ  
БҮХИЙ ХӨНДЛӨНГИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ  
БОЛОН АШИГЛАХ*

## **1.1 Татварын хяналт шалгалтан дахь баримт мэдээллийн ач холбогдол**

Татварын мэдээллийн систем нь татварын статистик мэдээ боловсруулах, татвар төлөгчдөд хяналт тавих, татварын хяналт шалгалт явуулах зэрэгт өргөнөөр ашиглагддаг маш чухал үүрэгтэй систем билээ. Ялангуяа татварын хяналт шалгалтыг үнэн зөв, үр дүнтэй явуулахад шаардлагатай мэдээ материал нь орлогоо өөрөө тодорхойлж татвараа тайлагнадаг татварын тогтолцооны шударга, тэгш байх зарчмыг бэхжүүлэхэд зайлшгүй чухал шаардлагатай зүйл юм.

Татварын хяналт шалгалтанд ашигладаг мэдээ материалыг «хөндлөнгийн мэдээлэл», эсвэл «татварын мэдээ материал» гэж нэрлэх бөгөөд тэдгээр нь нэгдүгээрт татвар төлөгчийн тайлан үл гаргалт, илүү дутуу тайлагналтийг хязгаарлан, тайлангаа бие даан үнэн бодитоор гаргах явдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Хоёрдугаарт татварын хяналт шалгалтанд шууд ач холбогдолтой бөгөөд татварын хяналт шалгалтанд хамруулах объектыг сонгох, хяналт шалгалтыг юунд чиглүүлэх вэ гэдгийг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлдэг.

Энэ бүлэгт ① татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий мэдээ материалыг ямар аргаар цуглуулах, ② цуглуулсан мэдээ материалыг яаж ашиглах вэ гэдгийг авч үзнэ.

## **1.2 Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба түүнийг цуглуулах арга**

Тус судалгааны хэсгээс урьд нь гаргасан «Хөндлөнгийн мэдээллийг цуглуулж ашиглах талаархи гарын авлага (төсөл)»-д үндэслэн, УТЕГ-аас 2002 оны 9 сарын 12-ны өдрийн УТЕГ-ын даргын 171 тоот тушаалаар «Татвар төлөгчийн холбогдолтой хөндлөнгийн мэдээллийг цуглуулах ба татварын хяналт шалгалтанд ашиглах журам» гарсан билээ. Тус журмаас үзэхэд татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийг ① Захиргааны байгууллагаас ирэх мэдээлэл, ② Иргэн ба аж ахуйн нэгж байгууллагаас ирэх мэдээлэл, ③ Татварын албаны дотоод мэдээллээс авах мэдээлэл, ④ Сонин хэвлэл, радио телевиз гэх мэт мэдээллийн хэрэгслээс авах мэдээлэл гэсэн 4 хэсэгт хувааж, мэдээлэл тус бүрийн эх үүсвэр болон түүний агуулга зэргийг зааж өгчээ.

Түүнчлэн зарим мэдээллийн хувьд түүнийг өгч байгаа байгууллагатай хийсэн гэрээний дагуу эсвэл УТЕГ өөрөө боловсруулалт хийн хөндлөнгийн мэдээллийн санд оруулж, татварын алба хэрэгтэй цагтаа мэдээлэл авч болох мэдээллийн бааз бүрдүүлэхээр ажиллаж байна.

Компьютераар боловсруулалт хийгдээгүй мэдээллийг цаасан мэдээлэл хэвээр нь ашиглах бөгөөд аль аль нь адилхан үнэ цэнэтэй мэдээлэл юм. Мэдээллийн бааз дахь мэдээллийг ашигласнаар ажлын бүтээмж, үр ашиг дээшлэх учраас аль болохоор мэдээллийн баазыг ашиглах нь чухал бөгөөд хөндлөнгийн мэдээллийн төрлөөс хамаарч компьютерээр боловсруулалт хийлгүйгээр цаасан мэдээлэл хэвээр нь ашиглах ёстой зүйл ч байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй.

Доорхи хүснэгтэнд татварын хяналт шалгалтанд чухал ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл, түүний эх үүсвэр, цуглуулах ажлыг хариуцах ажилтан, цуглуулах хугацаа зэргийг харуулав.

Хүснэгт 1-1 болон 1-2-т дурдах мэдээллийн ихэнх нь дээрх УТЕГ-ын даргын тушаалаар гарсан хөндлөнгийн мэдээллийн журамд тусгагдсан зүйл бөгөөд хүснэгт 1-1-д компьютерээр боловсруулалт хийх мэдээлэл (цаашид «компьютер боловсруулалт хийгдэх мэдээлэл»), хүснэгт 1-2-т цаасан мэдээллийг харуулав.

Мөн УТЕГ нь өнөөдөр цаасан хэлбэрээр боловсруулагдаж байгаа мэдээлэлд алсдаа компьютер боловсруулалт хийхээр төлөвлөж байгаа билээ.

**Хүснэгт 1-1 Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба цуглуулах ажлыг хариуцсан ажилтан  
(Компьютераар боловсруулах мэдээлэл)**

Мэдээллийн төрөл	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга	Цуглуулагч	Цуглуулах хугацаа
Гаалийн мэдээ	Гаалийн Ерөнхий Газар	Компьютерээр боловсруулалт хийх хөндлөнгийн мэдээллийн бааз (Гаалийн мэдээллийн баазаас хөрвүүлэх)	ҮТЕГ (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сар бүр 1 удаа
НӨАТ-ын падаан	НӨАТ төлөгч	НӨАТ төлөгчөөс татварын албанд гаргаж өгнө.  Компьютер боловсруулалт хийгдэх хөндлөнгийн мэдээллийн бааз	Татварын албад  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан, хяналт шалгалтын байцаагч нар)	Сар бүр 1 удаа
Спирт хуваарилалтын мэдээ	Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам	ХХААЯ-ны спирт хуваарилалтын мэдээнээс боловсруулах  Компьютер боловсруулалт хийгдэх хөндлөнгийн мэдээллийн бааз	ҮТЕГ (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сард 1 удаа
Спирт борлуулалтын мэдээ	Спирт үйлдвэрлэгч	Спирт үйлдвэрлэгчээс ирэх спирт боловсруулалтын мэдээнд тулгуурлан гаргана.  Компьютер боловсруулалт хийгдэх хөндлөнгийн мэдээллийн бааз	ҮТЕГ (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сард 1 удаа
Аж ахуйн нэгжийн суутган татварын тайлан  Маягт ТТ-11(2)	Суутган татвар төлөгч аж ахуйн нэгж	Татварын албанд тушаагдсан тайлан ТТ-11(2)-т тулгуурлан гаргана.  Компьютер боловсруулалт хийгдэх хөндлөнгийн	Татварын албад  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан, хяналт	Улиралд 1удаа



		мэдээллийн бааз	шалгалтын байцаагч нар)	
Аж ахуйн нэгжийн суутган татварын тайлан Маягт ТТ-11(3)	Суутган татвар төлөгч аж ахуйн нэгж	Татварын албанд тушаагдсан тайлан ТТ-11(3)-т тулгуурлан гаргана.  Компьютер боловсруулалт хийгдэх хөндлөнгийн мэдээллийн бааз	Татварын албад  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан, хяналт шалгалтын байцаагч нар)	Улиралд 1удаа
Хөндлөнгийн мэдээллийн хуудас	Татвар төлөгч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт	Хяналт шалгалтын үеэр олж авсан баримт мэдээ, хэвлэлийн мэдээ, иргэдийн мэдээлэл, хүмүүсийн яриа зэрэгт үндэслэнэ.  Компьютерээр боловсруулалт хийсэн хөндлөнгийн мэдээллийн бааз	Татварын албад  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан, хяналт шалгалтын байцаагч нар)	Тухай бүр

Хүснэгт 1-2 Татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл ба цуглуулах ажлыг хариуцсан ажилтан  
(Цаасан мэдээлэл)

Мэдээллийн төрөл	Эх сурвалж	Цуглуулах арга	Цуглуулагч	Цуглуулах хугацаа
ИБМ	ИБМТ	ҮТЕГ дээр графикт хугацаагаар иргэдийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл (шинээр бүртгүүлэх, шилжилт)-ийг цаасаар цуглуулна. (алсдаа ҮТЕГ-т компьютерт оруулна)	Татварын албад  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
ҮХХ-ийн бүртгэлийн мэдээ	ҮХХБГ	ҮТЕГ тогтоосон хугацаанд ҮХХ-ийн шилжилт (борлуулалт, бэлэглэл)-тэй холбоотой мэдээлийг цаасаар цуглуулна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна)	ҮТЕГ  (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Жилд 1 удаа
НД-ын мэдээ	НДГ	Бүх татварын албад тогтмол хугацаанд ААНБ-ын НД-ын шимтгэл төлөлттэй холбоотой мэдээг цаасаар авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээ	ЗЦГ	Татварын албад дээр тогтмол хугацаанд ТХ-ийн бүртгэлийн мэдээг цаасаар авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
Бууны бүртгэлийн мэдээ	ЦЕГ	Татварын албад тогтмол хугацаанд бууны бүртгэлийн мэдээг цаасаар авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Жилд 1 удаа
Алтны борлуулалтын мэдээ	Монгол банк, арилжааны банк, улсын үнэлгээний алба, АМХЭГ	ҮТЕГ тогтмол хугацаанд алтны борлуулалтын мэдээг цаасаар авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сард 1 удаа
Ашигт малтмалын лицензийн мэдээ	АМХЭГ	ҮТЕГ тогтмол хугацаанд ашигт малтмалын лицензийн мэдээг цаасаар авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр

Хувьцаа, ЗГ болон компанийн бондын арилжааны мэдээ	Хөрөнгийн бирж	ҮТЕГ тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
Тендерийн мэдээ	Төрийн захиргааны байгууллагууд	ҮТЕГ тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна. (алсдаа ҮТЕГ-т компьютерт оруулна )	ҮТЕГ (Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Тухай бүр
Алт олборлож, төсөл хэрэгжүүлсэн мэдээ	Монгол банк болон бусад арилжааны банк	ҮТЕГ тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
ҮХХ, авто тээврийн хэрэгсэл, малын даатгалын мэдээ	Даатгалын компани	ҮТЕГ тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна.(алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
Газрын түрээсийн мэдээ	Газрын албад	Татварын албад тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	Татварын албад(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
Бизнес эрхлэх лицензийн зөвшөөрлийн мэдээ	Орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын алба	Татварын албад тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна. (алсдаа ҮТЕГ дээр компьютерт оруулна.)	Татварын албад(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Улирал бүр
ОАТТ-ийн мэдээ	ҮТЕГ Хуулийн хэрэгжилтийг хангах хэлтэс	ҮТЕГ дээр тогтмол хугацаанд цаасаар мэдээ авна.	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сард 1 удаа
Гар талон	Татвар төлөгч	Татвар төлөгчөөс татварын албанд өгнө.(Алсдаа ҮТЕГ-т компьютераар боловсруулалт хийнэ.)	Бүх татварын алба(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Сард 1удаа

Төрийн өмч худалдан авсан мэдээ	Төрийн өмчийн хороо	ҮТЕГ тогтмол хугацаанд цаасаар авна.	ҮТЕГ(Хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан)	Жилд 1 удаа
---------------------------------	---------------------	--------------------------------------	--	-------------

### 1.3 Хөндлөнгийн мэдээлэл цуглуулах нэмэлт арга болон ашиглах арга

Дээрх хүснэгт 1-2-т татварын хяналт шалгалтанд ач холбогдол бүхий хөндлөнгийн мэдээллийн төрөл, эх сурвалж, цуглуулах арга, цуглуулах ажлыг хариуцсан ажилтан, цуглуулах хугацааны талаар авч үзлээ. Доор гол гол хөндлөнгийн мэдээллийг цуглуулах нэмэлт арга болон ашиглах тодорхой аргын талаар өгүүлнэ.

#### (1) ГЕГ-ын гаалийн мэдээ

Гаалийн мэдээ нь ААНБ болон хувь хүмүүсийн экспорт, импортын мэдээг агуулдаг учир тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн барааны хэмжээ, мөнгөн дүнд үндэслэн татвар ногдох орлогыг нь тодорхойлоход маш чухал материал болж өгдөг.

Тухайлбал экспортын мэдээг бараа, түүхий эдийн борлуулалтын дүнг, импортын мэдээг бараа, түүхий эдийн худалдан авалтын дүнг тогтооход ашиглаж болно.

Борлуулалт эсвэл худалдан авалтыг зуун хувь экспорт, импортоор хийдэг тохиолдолд тэдгээрийн жилийн тоо баримтанд үндэслэн борлуулалт, худалдан авалтын нийт дүнг тогтоож болох бөгөөд жилийн хэсэг хугацаанд хамааралтай тоо баримт байх тохиолдолд эдгээр тоо баримтыг ашиглан татварын хяналт шалгалтаар борлуулалт, худалдан авалтын нийт хэмжээг олж тогтоох шаардлагатай болно.

Ямар ч тохиолдолд гаалийн мэдээнд ААНБ-ын улсын регистрийн дугаар, иргэний хувьд иргэний регистрын дугаарыг бичдэг учраас ҮТЕГ-т татвар төлөгчийн бүртгэлийн дугаар (ААНБ-ын улсын регистрийн дугаар, иргэний регистрын дугаар нь татвар төлөгчийн бүртгэлийн дугаар болдог)-тай тулгаснаар тухайн экспортлогч, импортлогч нь ААНБОАТ, ОАТ, хэрэглээний татварын тайлангаа гаргаж өгсөн эсэхийг нь тогтоож болно. ААНБ-ын тухайд гэвэл татварын албанд гаргаж өгсөн тайлантай нь тулгаж гаалийн мэдээ тайланд үнэн зөв тусгагдсан эсэхийг шалгаж илүү, дутуу төлөлт, хуурамчаар тайлагнасан явдал илэрвэл хяналт шалгалтанд хамруулахаар сонгоно. Иргэний хувьд тайлан гаргахгүй байх явдал их гардаг учраас татварын албанд дуудан тухайн эрхэлж буй үйл ажиллагааных нь агуулгын талаар лавлан шаардлагатай гэж үзвэл татварын хяналт шалгалт явуулж, татвараа үнэн бодитоор тайлагнах талаар зөвлөгөө өгөхийн хамтаар татвар төлөгчөөр бүртгэн цаашид тайлангаа үнэн зөвөөр гаргах талаар удирдан чиглүүлнэ.

Цаашид ҮТЕГ, ГЕГ-ын хоорондох гэрээгээр иргэн гаалийн бүрдүүлэлт хийхдээ ҮТЕГ-аас гаргасан татвар төлөгчийн бүртгэлийн гэрчилгээ (бүртгэлийн дэвтэр)-гээ заавал үзүүлдэг болох юм. Ингэснээр экспорт, импортын үйл ажиллагаанаас татвар ногдох орлого олж буй иргэнийг тогтоох явдал хялбар дөхөм болж, импорт экспортын орлого, татвараа үл тайлагнагч иргэн яваандаа алга болох юм.

#### (2) НӨАТ-ын падаан

НӨАТ төлөх үүрэг хүлээгч нь татвар ногдуулах бараа бүтээгдэхүүн борлуулах болгондоо 3 хувь падаан (НӨАТ-ын падаан)-ыг бичиж, 1 хувийг өөртөө, хоёрдахь хувийг харилцагч талд, гуравдахь хувийг татварын албанд өгнө. Падааныг авсан харилцагч (худалдан авагч) нь НӨАТ-ын тайлангаа гаргахдаа худалдан авалттай холбоотой татварын хасалтын нотолгоо болгон уг падааныг татварын албанд өгнө. Татварын албаны хариуцсан байцаагч нь НӨАТ-ын падаан, тайланг тулган татварын хасалт үнэн зөв хийгдсэн эсэх, буцаан олголтын

дүн зөв эсэхийг шалгана.

Түүнчлэн НӨАТ-ын падаан нь падаан бичигчийн борлуулалттай холбоотой гүйлгээний дүнг илтгэх баримт учраас падаан бичигчийн ААНОАТ-ын тайлан дахь борлуулалтын дүн үнэн зөв эсэхийг шалгахад ашиглах баримт болно.

Татварын албанд НӨАТ-ын падаан маш их хэмжээгээр цугларах учраас тэдгээрийг борлуулагч, худалдан авагчийн тайланд тусгагдсан дүн үнэн зөв эсэх, тайлан үл гаргагч эсэхийг тогтоох материал болгон ашиглахын тулд РС боловсруулалт хийн хөндлөнгийн мэдээллийн баазад оруулах замаар ашиглана. Энэ тохиолдолд бүх татварын албанд гаргаж өгсөн НӨАТ-ын падааныг ҮТЕГ-т нэгтгэн оруулах болно.

Ямар нэгэн шалтгаанаар мэдээллийн баазад оруулах боломжгүй тохиолдолд татварын албанд өөрийн харьяа татвар төлөгчийн падааныг ялган авч, бусад татварын албанд харьяалагдах татвар төлөгчийн падааныг харьяа татварын албанд илгээх аргаар ашиглах болно.

### (3) *Спиртийн үйлдвэрийн борлуулалтын мэдээлэл*

Спирт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх гол түүхий эд болдог тул спиртийн үйлдвэрийн борлуулалтын мэдээ нь борлуулагч, өөрөөр хэлбэл, спирт үйлдвэрлэгчдийн татвар ногдох орлогыг тооцон гаргахад үндсэн үзүүлэлт болдог байна. Тухайлбал, архи үйлдвэрлэгчдийн спирт татан авалтын хэмжээ болон мөнгөн дүнг үндэслэн нийт үйлдвэрлэлийн хэмжээ, үйлдвэрлэлийн өртгийг тооцож чадвал бүтээгдэхүүн тус бүрийн борлуулалтын өртгийн хувийг үндэслэн борлуулалтыг орлогыг тооцож гаргах боломжтой.

Мөн спиртийг ямар үйлдвэрлэгчдэд хэдий хэмжээгээр үйлдвэрлүүлэх вэ гэдэг хуваарилалтын асуудлыг ХХАА-н яам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх газар болон Санхүү Эдийн Засгийн Яамны хэлэлцүүлгээр шийдэж, ХХАА-н яамнаас ҮТЕГ болон прокурорын газарт «Спирт хуваарилалтын мэдээ» хүргэгдэнэ. Үүнд спирт үйлдвэрлэгч (10 компани)-д хуваарилах хэмжээ, спирт үйлдвэрлэгч тус бүрийн архины үйлдвэрүүд (нийт 157 компани)-д хуваарилах хэмжээ тусгагдсан байдаг. Спирт үйлдвэрлэгчээс архи үйлдвэрлэгчдэд худалдсан тоо хэмжээний талаар «Спирт борлуулалтын мэдээ» -г ҮТЕГ-т сард 1 удаа гаргаж өгнө.

Иймээс архи үйлдвэрлэгчдийн хувьд дээрх мэдээ материалыг ашиглан үйлдвэрлэгч тус бүрийн архи үйлдвэрлэлийн хэмжээг багцаагаар тооцоолон гаргаж болох тул борлуулалтын өртгийг тооцож чадах юм бол бодит байдалд нэлээд дөхсөн борлуулалтын орлогыг эндээс тооцон гаргаж болох юм.

### (4) *Суутган татварын тайлан ТТ-11(2) ба ТТ-11(3)*

① Ажил гүйцэтгэлийн гэрээгээр аж ахуйн нэгж, байгууллагад ажил үйлчилгээ үзүүлж байгаа иргэн болон ② Түүхий эд материал аж ахуйн нэгжид борлуулж буй иргэний хувьд түүний аж ахуйн нэгж байгууллагаас авч буй ажлын хөлс, орлогоос тодорхой хувь хэмжээний орлогын татвар суутган авдаг билээ. Энэ тохиолдолд татварын суутгал хийсэн аж ахуйн нэгж нь ① дэх тохиолдлын хувьд «Суутган татварын тайлан ТТ-11(2)»-ыг, ② дахь тохиолдлын хувьд «Суутган татварын тайлан ТТ-11(3)»-ыг татварын албанд тушаадаг.

Эдгээр тайланд бичигдсэн ажлын хөлс болон орлого авсан иргэний орлогын мэдээлэл нь хөндлөнгийн мэдээллийн баазад орох тул ажлын хөлс болон орлого олсон иргэний татвар ногдох орлогыг тогтооход энэ нь ашиглагдах юм. Тухайлбал, аливаа иргэн нэг жилд хэд хэдэн аж ахуйн нэгжээс орлого олох тохиолдолд тухайн аж ахуйн нэгжүүдээс татварын албанд тушаах дээрх «Суутган татварын тайлан ТТ-11(2)»-ын дагуу түүнд бичигдсэн иргэний орлогыг «Хөндлөнгийн мэдээллийн бааз»-д хайх тул тэнд бичигдсэн хэд хэдэн

орлогыг нийлүүлэх замаар тухайн татвар төлөгчийн нэг жилд олсон нийт татвар ногдох орлогыг тогтоож болно.

(5) *Хөндлөнгийн мэдээллийн хуудас*

Хөндлөнгийн мэдээллийн хуудсыг хяналт шалгалтын байцаагч дараах тохиолдолд үйлддэг.

- 1 Татварын хяналт шалгалтын үед шалгалтанд хамрагдаж буй татвар төлөгчийн нягтлан бодох бүртгэл, нэхэмжлэх, гар талон гэх мэт анхан шатны бүртгэл, татвар төлөгч уг этгээд болон бусад этгээдээс асууж сонссон зүйл зэргээс тус хяналт шалгалтанд хамрагдагчийн харилцагч байгууллага (Байнгын үйлчлүүлэгч, худалдан авалт хийгдсэн газар, холбогдох бусад байгууллага)-ын талаарх татвар ногдуулалтын холбогдолтой төрөл бүрийн мэдээлэл (Борлуулалт, худалдан авалт, зардал) олж авсан тохиолдолд
- 2 Сонин сэтгүүл, телевизор гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслээс тодорхой нэгэн татвар төлөгчийн татвар ногдуулалтын холбогдолтой мэдээллийг олж авсан тохиолдолд
- 3 Татварын албанд тодорхой нэгэн татвар төлөгчийн татварын холбогдолтой мэдээлэл ирсэн тохиолдолд
- 4 Хот дотор байрлуулсан мэдээллийн самбар, байшин барилга, дэлгүүр лангуу шинээр нээгдэх, хүмүүсийн яриа зэргээс татварын холбогдолтой ямар нэгэн мэдээлэл орж ирсэн тохиолдолд
- 5 Бусад

Дээрх маягийн мэдээлэл нь татвар төлөгчийг болон татвар ногдох орлогыг тодорхойлоход шууд холбогдох мэдээлэл тул үүнийг хөндлөнгийн мэдээллийн үүднээс авч үзвэл үнэ цэнэтэй мэдээлэл юм.

Ялангуяа, татварын хяналт шалгалтаар илрүүлсэн давхар бүртгэл, далд арилжаа, давхар гүйлгээ гэх мэтийн зөрчил, борлуулалтын урамшуулал олгосон гэх мэт мэдээлэл нь харилцагч байгууллагын тайлангийн зөрчлийг илрүүлэх магадлал өндөртэй тул ихээхэн ашигтай мэдээлэл гэж хэлж болно.

Гэхдээ дээрх маягийн мэдээлэлд баттай бус мэдээлэл ч байж болох тул мэдээллийг ашиглах гэж буй хяналт шалгалтын байцаагч нь хяналт шалгалт хийх үедээ бодит байдлыг сайтар хянаж тогтоохын зэрэгцээ бусад холбогдох нотолгоо баримтанд тулгуурлан тухайн мэдээллийн найдвартай эсэхийг магадлах шаардлагатай юм.

Мөн иймэрхүү төрлийн мэдээллийг цуглуулах үедээ татварын байцаагч нь тэдгээрийг харилцагчийнх нь татварын мэдээлэл болгон ашиглах гэж буйгаа мэдэгдэхгүй байх тал дээр сайтар анхаарах хэрэгтэй юм. Мөн эдгээр мэдээллийг харилцагч байгууллагынх нь татварын хяналт шалгалтанд ашиглах тохиолдолд тэдгээрийг хаанаас авснаа татвар төлөгчөөс нууцлах шаардлагатай. Учир нь татварын хяналт шалгалтанд туслалцаа үзүүлж, мэдээлэл гаргаж өгсөн татвар төлөгчийн итгэлийг хөсөрдүүлж болохгүй юм.

(6) *Гар талон*

Гар талоны систем нь тодорхой хүрээний аж ахуйн нэгж ба хувь хүмүүст ҮТЕГ-аас гаргасан гар талоныг хэрэглүүлэх систем бөгөөд үүний талаарх Санхүү Эдийн Засгийн Сайдын тушаал хэдийнэ гараад байгаа билээ. Гэхдээ Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд энэхүү системийг даруй хэрэгжүүлэхэд татвар төлөгчийн ойлгож хүлээж авах болон хөрөнгө мөнгө, хэрэгжилтийн тал дээр төрөл бүрийн бэрхшээл тулгарч мэдэх юм.

Иймээс гар талоны системийг хэрэгжүүлэх ажлыг ажил гүйлгээний холбоотой данс бүртгэл хөтлөх, бүртгэх, хадгалахтай холбогдсон татвар төлөгчийн боловсролын байдал зэргийг харгалзан цаашид үргэлжлүүлэн тунгааж үзэх шаардлагатай юм.

(7) *Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс авах иргэний бүртгэлийн мэдээлэл*

Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд нийт иргэдэд регистрийн дугаар (Иргэний бүртгэлийн дугаар) олгож, 16 наснаас дээших насныханд иргэний үнэмлэх олгосноор нийт иргэдэд нэгдсэн нэг дугаараар төвлөрүүлэн хяналт тавьдаг.

ҮТЕГ-г ч мөн адил энэ удаагийн хэрэгжүүлж буй татварын мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд татвар төлөгч иргэний хувьд иргэний бүртгэлийн дугаарыг татвар төлөгчийн дугаар болгон хэрэглэснээр нийт татвар төлөгчид төвлөрсөн хяналт тавьдаг.

Мөн дээрх иргэний бүртгэлийн дугаар нь өнөөдөр ҮТЕГ төдийгүй бусад засаг захиргааны байгууллагад ч мөн адил нийтлэг журмаар өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд мэдээллийн сүлжээгээр дамжуулан засаг захиргааны байгууллагууд нь шаардлагатай мэдээллийг хамтдаа эзэмшиж байдаг.

ҮТЕГ-ын нэвтрүүлж буй татвар төлөгчийн бүртгэлийн системд байх ёстой зүйл бол бүх татвар төлөгчдөд давхардуулалгүй нэгдсэн нэг дугаараар төвлөрүүлэн хяналт тавихын хамт бусад засаг захиргааны байгууллагуудын хэрэглэж буй дугаартай нэгэн ижил дугаартай болгох замаар бусад засаг захиргааны байгууллагаас орж ирсэн төрөл бүрийн мэдээллийг компьютерт боловсруулалт хийж, мэдээллийн баазад нэн даруй оруулдаг болгох явдал юм. Ийм системийг бий болгосноор татварын албаны мэдээллийн системийг маш хурдан хугацаанд бүрдүүлж чадах юм.

Иргэний бүртгэл мэдээллийн төвөөс авах мэдээлэл нь иргэний бүртгэлийн дугаар (регистрийн дугаар), паспортын дугаар, эсхүл иргэний үнэмлэхийн дугаар, овог нэр, хаяг зэрэг бөгөөд эдгээрийг болон татварын албадын харьяалах татвар төлөгчийн бүртгэлийн дугаарыг тулган үзсэнээр тухайн татварын албаны тухайн татвар төлөгчийн харьяалал зөв эсэхийг тогтоож болно.

Мөн татварын албад дахь татвар төлөгчийн бүртгэлийн дугаар нь татвар төлөгчийн төв мэдээллийн бааз дахь татвар төлөгчийн дугаартай ижил дугаар байдаг тул татвар төлөгчийн төв мэдээллийн бааз дахь татвар төлөгчийн бүртгэлийн дугаарыг хайснаар тухайн татвар төлөгчийн хаяг болон харьяалах татварын албыг шалгаж болно.

Татвар төлөгчид нь оршин байгаа хаяг зэргийн өөрчлөлтөөс болж бүртгүүлэх ёстой байсан татварын алба өөрчлөгдөх тохиолдолд энэхүү өөрчлөлтийн бүртгэлийг хийхийн зэрэгцээ шинэ оршин байгаа газрыг харьяалах татварын албанд шинээр бүртгүүлнэ. Татвар төлөгч бүртгүүлэх процедурыг хийгээгүй тохиолдолд иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс авсан мэдээллийн дагуу шилжилт хөдөлгөөн хийгдсэн эсэхийг тогтоох тул тухайн татвар төлөгчийн бүртгэлд өөрчлөлт хийж болно. Мөн шинээр шилжиж ирсэн татвар төлөгчийн хувьд нэгэн адил иргэний бүртгэл мэдээллийн төвөөс авсан мэдээлэлд үндэслэн шилжиж ирсэн тухайг тогтоож болох тул татварын албанд шилжин ирсэн тухай холбогдох бүртгэлийг хийлгээгүй татвар төлөгчийн хувьд бичиг баримтын тулгалт хийж, мэдээлэл гарган авч, газар дээрх хяналт хийх зэрэг аргаар татвар төлөгчийг бүртгэх ажлыг зохицуулж болно.

Мөн оршин байгаа хаяг зэрэг нь өөрчлөгдсөн ч иргэний бүртгэл мэдээллийн төвд холбогдох өөрчлөлтийг хийлгээгүй тохиолдолд шийтгэл ногдуулахаар тогтоосон байдаг бөгөөд оршин байгаа хаягаа өөрчилсөн ч шилжиж ирсэн ба шилжсэнтэй холбогдох өөрчлөлтийн бүртгэлийг хийгээгүй татвар төлөгч ч гарч мэдэх юм. Ийм тохиолдолд шилжилт хийгдэхээс өмнөх татварын албаны харьяалах татвар төлөгч хаана оршин байгаа нь тодорхойгүй болох бөгөөд шилжиж очсон газраа орлого олж буй мөртлөө татвараа тайлагналгүй татвараас гадуур үлдэх тохиолдол гарч ирж болно. Иймээс энэхүү тохиолдолд шилжилт хийгдэхээс өмнө харьяалж байсан татварын алба нь хуучин оршин суугаа газар дахь ойр орчмынх нь ард иргэдээс асууж, шилжиж очсон газрын тухай ямар нэгэн мэдээлэл олж авах замаар шилжин очсон газрыг тодорхойлохын тулд хичээн ажиллах хэрэгтэй юм. Мөн шинээр шилжиж очсон газрыг харьяалах татварын алба нь харьяалах нутаг дэвсгэрт

тогтмол хяналт шалгалт хийж, татварын албанд бүртгүүлэлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа татвар төлөгчийг тодорхойлохын тулд хичээж ажиллах хэрэгтэй юм.

*(8) Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газраас орж ирэх үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл*

Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл нь арилжаа наймаа, бэлэглэл, барьцаа өгөх гэх мэт ажил гүйлгээ явагдсан үед хийгдэх зүйл бөгөөд эдгээр мэдээллийг үндэслэн үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийг шилжүүлэх, эсхүл үл хөдлөх хөрөнгө ашиглалтын байдал зэргийг тогтоож болно. Үүгээр үл хөдлөх хөрөнгийн арилжаа явагдсан үед үл хөдлөх хөрөнгө шилжүүлэгчид «үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого (шилжүүлсний орлого 2%)», үл хөдлөх хөрөнгө хүлээн авагчид үл хөдлөх хөрөнгө эзэмших тохиолдолд жил бүр «үл хөдлөх хөрөнгийн татвар (үнийн дүнгийн 0,6%)» ногдуулна. Мөн бэлэглэлийн үед үл хөдлөх хөрөнгө бэлгэнд авагчид жил бүр «үл хөдлөх хөрөнгийн татвар (үнийн дүнгийн 0,6%)» ногдоно.

Мөн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн мэдээлэлд аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар болон хувь хүний иргэний бүртгэлийн дугаар агуулагдах бөгөөд арилжаа наймаа, бэлэглэлтэй холбоотой мэдээллээс барьцаа өгөх шалтгаан болсон ажил гүйлгээг тодорхойлсноор татвар ногдох орлоготой холбоотой ажил гүйлгээ хийгдсэн эсэхийг тодорхойлох боломжтой болно. Тухайлбал, барьцаа өгсөн явдал нь мөнгөний зарцуулалтын балансад хамаарагдаж байвал зээлдүүлэгчийн хувьд тэрхүү мөнгөний эх үүсвэрийг тодорхойлсноор, харин зээл авагчийн хувьд тэрхүү мөнгөн хөрөнгийн зарцуулагчийг тогтоосноор татвар ногдуулах орлоготой холбоотой ямар нэгэн ажил гүйлгээ хийгдсэн эсэхийг тогтоож болно.

*(9) Нийгмийн даатгалын газраас ирэх нийгмийн даатгалын мэдээлэл*

Нийгмийн даатгалын хураамж нь ажил үйлчилгээ эрхлэгчийн ажилтанд олгох цалингийн хэмжээнд үндэслэн тооцогдож гарах зүйл тул нийгмийн даатгалын хураамжийн төлбөр хийгдсэн гэдэг нь ажилтанд цалин хөлс төлөгдсөн гэсэн хэрэг болно. Цалингийн төлбөр хийгдсэн бол мэдээж тухайн орлогын татварт дундын суутгалын асуудал гарч ирэх тул нийгмийн даатгалын хураамжийн төлбөртэй холбоотой мэдээлэл нь татварын албаны хувьд татварын хяналт шалгалтыг явуулахад чухал мэдээлэл болно.

Суутган татварын хэмжээний хувьд ч гэсэн нийгмийн даатгалын хураамжийн дүнгээс цалингийн дүнг тооцон гаргаж болох тул нийгмийн даатгалын хураамжийн төлбөрийн хэмжээнээс суутган татварын төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг шалган тогтоох юмуу төлөгдөөгүй дүнг тооцон гаргаж болно.

*(10) Бусад мэдээлэл*

Өмнө өгүүлсэн хүснэгт 1-2-т дурдсан бусад мэдээллүүд нь татвар тайлагнах ёстой татвар төлөгчийг тогтоох, татварын албанд тушаагдсан тайланд тусгагдсан татвар ногдох орлого болон татвар ногдох дүнгийн үнэн зөв эсэхийг тогтоох хэрэгслийн хувьд аль аль нь үр ашигтай мэдээлэл юм.

Иймээс мэдээллийн эх сурвалж болох засаг захиргааны байгууллагуудын туслалцааг авах юм бол ҮТЕГ болон бусад татварын албад дээр хөндлөнгийн мэдээлэл хариуцсан ажилтан цаасан буюу дискээр мэдээлэл цуглуулах ажилд тогтмол болон ээлжит графикаар гарч, татвар төлөгчийн төв мэдээллийн бааз дахь татвар төлөгчийн бүртгэлийн дугаартай тулгалт хийж, татвар төлөгч тус бүрийн харьяалах татварын албыг гаргаж, тухайн мэдээллийг тухайн харьяалах татварын албанд хүргүүлнэ. Түүнийг хүлээн авсан татварын алба нь татвар тайлагнах ёстой этгээдийг тогтоож, хяналт шалгалтанд хамруулах сонголтыг хийж, улмаар тайлагнасан татварын дүнгийн үнэн зөвийг шалгах шалгалтанд ашиглана.



Дээрх үйл ажиллагаанууд нь компьютераар боловсруулалт хийж, хөндлөнгийн мэдээллийн баазад оруулах боломжгүй байлаа ч заавал хийх ёстой зүйл бөгөөд хөндлөнгийн мэдээллийг татварын хяналт шалгалтанд ашиглах мэдээллийн ажлын үндсэн хэсэг болох юм.

Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн мэдээллийн баазын ашиглалт нь хөндлөнгөөс орж ирэх асар их хэмжээний мэдээллийн зөвхөн нэгээхэн хэсгийг компьютерт боловсруулалт хийх замаар ажлын үр ашгийг дээшлүүлэх явдал төдийхөн бөгөөд үр ашигтай мэдээллийг цуглуулж, үүнийг хяналт шалгалтанд ашиглах ажил нь компьютераар хийгдэх ажил гэхээсээ илүү хяналт шалгалтын байцаагч хүн хэр зэрэг толгойгоо ажиллуулснаас шалтгаалах зүйл юм гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу.

# **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

*ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААРААР ТАТВАР ТӨЛӨГЧИЙГ  
ХЯНАХ ХЯНАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН  
ТАВИГДАЖ БУЙ АСУУДЛУУД*

## **2.1 Татвар төлөгчийн дугаараар татвар төлөгчийг хянах хэрэгцээ шаардлага**

Үнэн зөв, тэгш шударга татвар ногдуулалтыг хэрэгжүүлэхэд татварын албанд хамгийн анхаарах зүйл бол хуулинд заасны дагуу татвар төлөх үүргээ биелүүлэх шаардлагатай татвар төлөгчийн хяналтыг маш сайн зохион байгуулалттай хэрэгжүүлэх явдал юм.

Иргэн бүр өөрийн татварын ачаалал даах чадварт тааруулан татвар төлөх шаардлагатай тул, адил орлоготой атал зарим хэсэгт нь татвар ногдуулж, эсвэл татвар ногдуулахгүй байх явдлыг хэрхэвч зөвшөөрч болохгүй нь мэдээжийн хэрэг юм. Үүний тулд, татвар төлөгчийг харъяалах татварын алба нь хуулинд заасны дагуу тодорхой байхын зэрэгцээ татварын албад өөрийн хариуцах бүх татвар төлөгчийг хамруулан олж тогтоох, олж тогтоосон татвар төлөгчид бодитой хяналт тавих шаардлагатай байдаг. Ингэснээр татвараа өөрөө тодорхойлж тайлагнах систем болон нийт татварын систем бодит үр дүнтэй байх үндэс бүрэлддэг.

## **2.2 Монгол улс дахь татвар төлөгчийн хяналтын өнөөгийн байдал**

Монгол улс дахь татвар төлөгчийн хяналт нь татвар төлөгч аж ахуйн нэгж болон татвар төлөгч хувь хүнд олгосон «татвар төлөгчийн дугаар»-д голлон тулгуурладаг. Татвар төлөгчийн дугаар нь улсын хэмжээнд давхардахгүй, бүх татвар төлөгчийг нэг газарт төвлөрүүлэн хянах боломжтой байхаар олгогддог.

Ялангуяа, 2002 оны 1 сараас хэрэгжүүлж буй татвар төлөгчийн орчин үеийн мэдээллийн систем болох ORACLE-ийг нэвтрүүлэхтэй уялдан аж ахуйн нэгж, байгууллага болон татвар төлөгч хувь хүний бүртгэлийн дугаар нь тухайн хариуцах татварын албаны мэдээллийн баазад бүртгэгдэхийн зэрэгцээ татвар төлөгчийн төв мэдээллийн баазад нэгэн зэрэг бүртгэгдэх болсон тул улсын хэмжээнд аль ч татварын албанд татвар төлөгчийн дугаарыг хайж шалгах замаар төв мэдээллийн баазаас нийт татвар төлөгчийн мэдээллийг олж авах боломжтой болох юм.

## **2.3 Татвар төлөгчийн дугаарыг шалгах**

Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага болон хувь хүнд олгогдох татвар төлөгчийн дугаарыг хэрхэн шалгадаг талаар нарийвчлан авч үзье.

### **(1) Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн дугаар**

Аж ахуйн нэгж, байгууллага нь ҮТЕГ-ын харьяа Улсын бүртгэл мэдээллийн төвд аж ахуйн нэгжийн бүртгэлийг хийснээр аж ахуйн нэгжийн гэрчилгээ олгогдоно. Үүнд мөн төсвийн байгууллага, олон улсын байгууллага, шашны байгууллага, хөрөнгө оруулагч зэрэг санхүүгийн байгууллага орно.

Улсын бүртгэл мэдээллийн төвд бүртгэлийн дарааллаар 13 оронтой дугаар олгогдохын зэрэгцээ үүнээс тусад нь аж ахуйн нэгж, байгууллагын татвар төлөгчийн дугаар болох 17 оронтой улсын регистрын дугаар олгогдоно.

Улсын регистрын дугаар нь аж ахуйн нэгж, байгууллагын татвар төлөгчийн дугаар болох тул урьдчилан ҮТЕГ-ын мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын хэлтэст бэлтгэсэн дугаар байх ба бүртгүүлсэн аж ахуйн нэгжид бүртгэлийн дарааллын дагуу олгогдох тул давхардсан дугаар гардаггүй.

Өөрөөр хэлбэл, ҮТЕГ-ын мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын хэлтэс урьдчилан бэлдсэн регистрын дугаарыг буулгасан гэрчилгээг хэвлэж гарган Улсын бүртгэлийн албанд өгөх ба тэндээс Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэлийн дарааллын дагуу олгогдоно. Мөн салбар компани болон төлөөлөгчийн газрын тухайд татварын алба тухайн татвар төлөгчийн дугаарыг бүртгэсэн гэрчилгээг салбар компанид олгоно

### **(2) Татвар төлөгч иргэний бүртгэлийн дугаар**

Татвар төлөгч иргэний бүртгэлийн дугаарт Иргэний бүртгэл мэдээллийн төвд төрөх үед нь бүх иргэдэд олгогдох хувь хүний регистрийн дугаар хэрэглэгдэнэ. Уг хувь хүний регистрийн

дугаар нь тухайн хүний насан туршид нь тогтвортой хэрэглэгдэх ба тухайн иргэн 16 нас хүрэхэд хувийн регистрийн дугаарын дагуу иргэний үнэмлэх олгоно. Энэхүү дугаар нь баруун талаас дүүрэг тус бүрийн кодын дугаар (2 орон), төрсөн он сар өдөр (6 орон), хүйс тус бүрээрх тоо (эр бол 1,3,5,7,9 сондгой тоо, эм бол 2,4,6,8 тэгш тоо) алдаа таних код (1 орон), нийт 10 оронтой давхардахгүй дугаар байна. (алдаа таних код бодох арга болон 10 оронтой хувь хүний регистрийн дугаарын талаар дараах 3-р хуудаснаас харна уу) Мөн гадаадын харьяалалтай болон харьяалалгүй иргэний тухайд татварын алба тусгай дугаар олгоно.

(3) Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар болон бусад төрийн захиргааны байгууллага хоорондын харилцаа холбоо

Дээр дурдсан татвар төлөгчийн дугаар болох аж ахуйн нэгж, байгууллагын улсын регистрын дугаар болон хувь хүний регистрын дугаар нь өнөөдөр ҮТЕГ-аас бусад төрийн захиргааны байгууллага, эсвэл хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид өргөн хэрэглэгддэг. Тухайлбал, ГЕГ-т гаалийн бүрдүүлэлт хийх үед аж ахуйн нэгж, байгууллагын улсын регистрын дугаар болон хувь хүний регистрын дугаарыг бичих шаардлагатай байдаг. Мөн Улсын бүртгэлийн алба болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, банк, Цагдаагийн газар, Гадаадын иргэдийн бүртгэлийн газар, Хилийн цэргийн удирдах газартай регистрын дугаарын мэдээлэл байнга солилцдог. Улмаар, банкны дансны дугаар болон компанийн даатгалын дугаарт мөн адил уг регистрын дугаар хэрэглэгддэг. Иймд, татвар төлөгчийн дугаар нь зөвхөн татварын албаны хүрээнд татвар төлөгчид хяналт тавих зорилгоор хэрэглэгдээд зогсохгүй, бусад төрийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагад хэрэглэдэг. Иймд эдгээр байгууллагыг сүлжээнд холбовол бусад төрийн захиргааны байгууллага дахь татварын албанд хэрэг болох мэдээллийг хялбар олж авах боломжтой. Иймд цаашид төрийн захиргааны байгууллага мэдээлэл солилцох хамтын ажиллагааны процедурыг улам цэгцлэх шаардлагатай юм. (одоогийн байдлаар, ГЕГ болон архи үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж зэрэг зарим байгууллагаас л мэдээлэл хүлээн авдаг.)

(жич) Хувь хүний регистрын дугаарыг алдаа таних кодоор тооцох арга

Дор дурдах жишээг хувь хүнд үнэн зөв регистрын дугаар олгохын тулд УБА-с регистрын дугаарыг бүртгэх байцаагчид зориулж гаргасан гарын авлага «хувь хүний регистрын дугаарын мэдээлэл»-аас иш татав.

Жишээ: Ховд аймгийн Чандмань сумд 1976 оны 12 сарын 4-нд төрсөн эрэгтэй хүүхдийн регистрын дугаар нь: РН-761204-10 болно.

Р - Ховд аймаг; Н-Чандмань сум; (нөөц код нь 10)

76 - Төрсөн он (төрсөн оны сүүлийн 2 үсэг); 12- төрсөн сар, 04 - төрсөн өдөр, 1 - эрэгтэй, 0 – алдаа таних код

5	6	7	8	9	8	7	→	хувийн жин (тогтмол тоо)
x	x	x	x	x	x	x	→	төрсөн он сар өдөр, хүйс
7	6	1	2	0	4	1	→	
↓	↓	↓	↓	↓	↓	↓		
$35+36+7+16+0+32+7=133$								

Нийлбэр дүн 133 -г 11-д хуваана.  $133 \div 11 = 12 \dots 1$  үлдсэн 1

Үлдсэн 1-д 10 гэсэн аймаг, сумын нөөц кодыг нэмнэ.  $1 + 10 = 11$

Энэ нэмсэн тоо нь 10-с илүү гарах тул 11-г хасна.  $11 - 11 = 0$  Энэ нь алдаа таних код 0 болно.

Иймд, энэ аргаар бодож гаргах алдаа таних код нь хэн ч тооцсон нэгэн адил дүн гарах тул үүнээс өөр тоо гарах тохиолдолд, төрсөн он сар өдөр, эсвэл хүйс нь буруу бичигдсэн болох тул дугаар үнэн зөв эсэхийг хянана.

Гэхдээ, нэг дүүрэгт, адил өдөр 5-с дээш эрэгтэй хүүхэд болон 5-с дээш эмэгтэй хүүхэд төрсөн тохиолдолд дугаар давхардах тул аймаг, хот, дүүрэг болгоны дугаарын 2 дахь үсгийг өөрчлөх замаар дугаар давхардахаас урьдчилан сэргийлнэ. Өөрөөр хэлбэл, нэг аймаг дотор дунджаар 22 сум байна гэж үзвэл тус бүрийн үсгээр нь дугаар олгогдох ба цагаан толгойн 35 үсгээс 13 үсэг нь ( $35-22=12$ ) илүү гарах тул уг 13 үсгийн дотроос сонгоно. Үүний дүнд, эрэгтэй, эмэгтэй тус бүр 65 нэр ( $13 \times 5=65$ ) хүртэл шинэ дугаар олгох боломжтой болох ба нийтдээ эрэгтэй, эмэгтэй тус бүр 70 нэр ( $5+65=70$ ) хүртэл боломжтой болно.

Иймд өнөөдөр Монгол улсын төрөлтийн үзүүлэлтийг (Улаанбаатар хотын 9 дүүргийн нийлбэр нь дунджаар 12,000 хүн, 1 дүүрэгт өдөрт дунджаар 3-4 хүн)-р бодож үзвэл, ойрын ирээдүйд улсын бүртгэлийн регистр давхардах асуудал гарахгүй гэж үзэж болно. ҮТЕГ энэ асуудалд мөн адил байр суурьтай байгаа болно.

## 2.4 Татвар төлөгчийн бүртгэл болон дугаар

Татвар төлөгчийн дугаар нь татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлэх замаар олгогдох дугаар юм. Дор дурдах «татвар төлөгчийн бүртгэлийн журам» (2001 оны 6 сарын 29-ний өдрийн ҮТЕГ-ын даргын 119 тоот тушаал)-д тулгуурлан татвар төлөгчийн бүртгэлийн процедурыг авч үзье.

(1) Татвар төлөгчийн дугаар олгоход анхаарах зүйл:

- A Татвар төлөгчийн дугаар нь давхардахгүй байна.
- B Татвар төлөгч нэг болон түүнээс дээш татварын албанд харъяалагдах тохиолдолд татвар төлөгчийн дугаар нь нэг байна.
- C Татвар төлөгчийн татварын албанд тушаах данс бүртгэл, татварын тайланд татварын төлөгчийн дугаарыг тэмдэглэсэн байна.
- D Татвар төлөгч бусад аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнтэй хийсэн бүх төрлийн мөнгөн гүйлгээнд хамаарах анхан шатны баримтанд өөрийн татвар төлөгчийн дугаарыг заавал бичиж, харилцагчаас өгөх анхан шатны баримтанд татвар төлөгчийн дугаараа бичих шаардлагатай.

(2) Татвар төлөгчийн бүртгэлийн хугацаа

AТатвар ногдох орлого бүхий хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, дундын суутгал хийх үүрэг хүлээгч Монгол улсын нутаг дэвсгэр дээр орлого олж байгаа гадаадын харъяалтай иргэн зэрэг түр оршин суугч тухайн үйл ажиллагааг эхэлснээс хойш 10 хоногийн дотор татварын албанд татвар төлөгчийн бүртгэл хийлгэх шаардлагатай.

B Орлогоос гадна татвар ногдох эд зүйлс бүхий хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага уг эд зүйлсийг эдэлж эхэлснээс хойш 1 сарын дотор татварын албанд бүртгүүлэх шаардлагатай.

CТатвар төлөгч бүртгэлд тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрд энэхүү өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор татварын албанд мэдэгдэж татвар төлөгчийн бүртгэлд өөрчлөлт хийлгэх шаардлагатай.

(3) Татвар төлөгчийг бүртгэх харъяалал

A Аж ахуйн нэгжийн хувьд;

- (A) Өөрийн хөрөнгийн хэмжээ 500 сая төгрөгөөс дээш, тэрчлэн татвар төлөгчийн үйл ажиллагаа нь аймаг, нийслэл, орон нутгийг хамарсан, тухайн орон нутагт өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулсан аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага нь → ҮТЕГ-ын төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газар (хуучин том татвар төлөгчийн газар)
- (B) Татвар төлөгчийн өөрийн хөрөнгийн хэмжээ 100 сая төгрөгнөөс дээш, түүнчлэн татвар төлөгчийн үйл ажиллагаа нь нийслэлийн газар нутгийн хэмжээнд явагдаж, салбар, төлөөлөгчийн газар нь дүүргүүдэд байгуулагдсан аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага нь → нийслэлийн татварын албанд харъяалагдана.

(C) (A) болон (B)-с бусад аж ахуйн нэгж, байгууллагын хувьд → аймаг, дүүргийн татварын албаны харъяа байна.

- ① Татвар төлөгч өөрийн ажлын байртай тохиолдолд ажлын байрны байршлаар тухайн нутаг дэвсгэрийн татварын алба
- ② Татвар төлөгч нь ажлын тусгайлсан байргүй, түрээсийн болон амьдран суудаг хувийн орон байрандаа үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд эзний оршин суугаа нутаг дэвсгэрийн татварын алба
- ③ Гадаадын ААН-ын хувьд тэдгээрийн ажил үйлчилгээ эрхэлж буй нутаг дэвсгэрийн татварын алба

*B Хувиараа хөдөлмөр, ажил үйлчилгээ эрхлэгч иргэдийн хувьд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн татварын алба*

*C Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний хувьд тухайн ажил үйлчилгээ эрхэлж буй нутаг дэвсгэрийн татварын алба*

*D Монгол улсад түр оршин суугч иргэний хувьд өөрсдийн оршин сууж буй нутаг дэвсгэрийн татварын алба*

*E Орлогоос бусад зөвхөн татвар ногдох зүйл эзэмшиж буй иргэн нь тухайн эзэмшиж буй зүйл нь оршин буй нутаг дэвсгэрийн татварын албанд*

*F Орлогоос бусад татвар ногдох зүйлийг эзэмшиж, тэр нь тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлж буй нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрт байгаа бол тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд*

(4) Татвар төлөгчийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах ба бүртгэлээс хасах

Татвар төлөгчийн бүртгэлийн агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд татвар төлөгчийг шинээр бүртгэхтэй адил ① Татвар төлөгч өөрөө бүртгүүлэх, ② Татварын хяналт шалгалтаар илэрсний үр дүнд бүртгэх гэсэн хоёр арга бий. Мөн «татан буулт(дампуурал)», «шилжилт хөдөлгөөнөөр»-өөр бүртгэлээс хасагдах тохиолдолд татварын өртэй эсэхийг заавал шалгаж, хэрвээ татварын өр байхгүй тохиолдолд татвар төлөгчийг бүртгэлээс хасч болно.

(5) Татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөн

*A Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс нь журмын дагуу ажлын байр болон оршин суугаа газраа өөрчилсөн татвар төлөгчтэй холбоотой баримт мэдээллийг цуглуулан эмхэтгэж, шинээр очсон ажлын байр болон оршин суугаа газрыг харьяалах татварын албадад хүргүүлнэ.*

*(жич) Энэ процедур нь урьд харьяалагдаж байсан болон шилжин очих татварын алба хооронд татвар төлөгч болон татвар төлөгчийн талаарх бүх төрлийн мэдээллийг дамжуулах талаар заасан заалт бөгөөд мэдээлэл дамжуулах хугацааг заагаагүй боловч шилжилтийн бүртгэл хийлгэх өргөдөл гарсан тохиолдолд түргэн шуурхай дамжуулах шаардлагатай.*

*B Татвар төлөгчийн татварын алба хооронд хийгдэх шилжилт хөдөлгөөнийг жилд нэг удаа, төсвийн тодотгол болон дараа жилийн төлөвлөгөө хийхээс өмнө энэ журамд заасан зарчмыг үндэс болгон ҮТЕГ-ын даргын тушаалаар татварын албадад хүргүүлнэ.*

*(жич) Энэ процедур нь ҮТЕГ-ын даргын тушаалаар хуучин харьяалж байсан болон шинээр шилжин очих татварын албанаас бусад бүх татварын албанд тухайн татвар төлөгчийн талаарх мэдээллийг хүргэх талаар заасан заалт юм.*

*C Татварын алба нь шилжилт хөдөлгөөний мэдээг үндэслэн татвар төлөгчийг шинээр бүртгэх, бүртгэлээс хасах асуудлыг зохицуулна.*

(жич) Энэ процедур нь татвар төлөгч өргөдөл гаргасан тохиолдолд төдийгүй, татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөний талаар ямар нэгэн мэдээллийг татварын алба олж авсан бол нэн даруй бүртгэл хийх шаардлагатай талаар заасан заалт юм.

(6) Татвар төлөгчийн бүртгэлийг мэдээллийн баазад оруулах нь

Дээр дурдсан татвар төлөгчийн «шинээр хийх бүртгэл», «өөрчлөлтийн бүртгэл», «бүртгэлээс хассан тухай тэмдэглэл» нь бүх татварын албанд тухай бүр татварын төлөгчийн мэдээллийн баазад орох ба УТЕГ-т нийт татвар төлөгчид нэгдсэн хяналт тавина. Мөн шинээр бүртгэх тохиолдолд, аж ахуйн нэгж, байгууллага нь Улсын бүртгэлийн албанд, хувь хүний хувьд, харьяалах татварын албанд тус тусын бүртгэл хариуцсан байцаагч эсвэл хариуцах татварын байцаагч бичилт хийх маягтыг боловсруулах ба үүнийг эдийн засагч мэдээллийн баазад оруулна. Дараа нь тухайн татварын албаны татвар хураалтын тасаг, хэлтсийн дарга эсвэл, хүн амын орлогын албан татварын хэлтсийн даргын удирдлага хяналтын дор «татвар төлөгчийн хувийн хэрэг»-ийг нээнэ. Татвар төлөгчийг бүртгэлээс хасч «татвар төлөгчийн хувийн хэрэг»-ийг хаах тохиолдолд, мөн адил процедурын дагуу хийгдэнэ. Мөн өөрчлөлт хийх бүртгэлийн хувьд, УБА-ны мэдээллийн бааз болон хотын татварын хэлтэс, мөн дүүргийн татварын албаны мэдээллийн баазтай долоо хоног бүр бичилт тулгах замаар хийнэ.

## **2.5 Татвар үл тайлагнагчийг илрүүлэхэд гардаг бэрхшээлүүд ба түүнийг шийдвэрлэх арга зам**

Татвар төлөгчийг хянахад хамгийн чухал зүйл бол тухайн татварын алба өөрийн харьяалах нутаг дэвсгэрт орших татвар төлөгчийг нэг бүрчлэн олж тогтоох (өөрөөр хэлбэл, татварын тайлан гаргадаггүй татвар төлөгч байхгүй байх) явдал юм. Татвараа үл тайлагнах явдал нь, ① Татвар төлөгч шинээр үйл ажиллагаа явуулж эхлэх тохиолдолд, ② Бусад татварын албад хооронд шилжилт хөдөлгөөн гарсан тохиолдолд үүсэх нь их байдаг.

Татвар төлөгчийг шинээр бүртгэх, түүний шилжилт(харьяаллаас гарах болох шинээр харьяалалд орох) хөдөлгөөнийг бүртгэх үйл ажиллагааг нягт нямбай явуулсан тохиолдолд энэ асуудал үүсэхгүй хэдий ч энэ зарчмыг заавал ч үгүй хатуу мөрдөж ажиллана гэсэн баталгаа байхгүй юм. Энэхүү тохиолдолд татварын алба өөрөө Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс иргэний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг авч, түүний үндсэн дээр татвар төлөгчийн хуучин харьяалагдаж байсан газар болон шинээр ирсэн газрыг нягтлан шалгаж, тухайн хоёр татварын албад хоорондох шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бүртгэлийг баталгаажуулж байх шаардлагатай юм.

Хэрвээ татвар төлөгч ямар нэгэн өргөдөл, мэдэгдэл хийлгүйгээр ажлын байр болон оршин суугаа байр сууцаа өөрийн харьяалагдах татварын албаны харьяа нутаг дэвсгэрт, эсхүл бусад татварын албаны харьяаны нутаг дэвсгэрт өөрчлөн шилжүүлэх тохиолдолд дээр дурдсан мэдээлэлд тулгуурлах боломжгүй болно. Энэ тохиолдолд татварын албаны ажилтан өөрийн татварын албаны харьяа нутаг дэвсгэрийг нэг бүрчлэн байнга эргэж тойрч, шинээр ажил үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох тал дээр хичээж ажиллахын зэрэгцээ бусад татварын албаны харьяалах нутаг дэвсгэрт шилжсэн татвар төлөгчийн хувьд, түүний хуучин байрлаж байсан газарт нь очиж, ойр орчмынх нь хүмүүсээс асууж мэдэх нь зүйтэй юм.

Мөн аж ахуйн нэгж, байгууллагын хувьд авч үзэхэд сүүлийн үед Улсын бүртгэлийн албанд шинээр аж ахуйн нэгж байгуулах өргөдөл хүлээн авахдаа тухайн өргөдөл гаргагчийн гэр бүл болон өргөдөл гаргагчтай холбоо харилцаатай байдаг хүний овог нэр, хаяг, эрхэлдэг ажил, холбоо барих утас зэргийг бичдэг болсон тул шилжсэн хаяг байршлыг нь олж тогтооход харьцангуй хялбар болсон. Үүнтэй уялдаад хаяг байршил нь тодорхойгүй татвар төлөгчийн тоо цөөрсөн байна. Түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэхдээ Улсын бүртгэлийн алба болон харьяа татварын албад хамтран ажиллаж тухайн аж ахуйн нэгж үнэн зөв өргөдөл өгсөн эсэхийг ажлын байран дээр нь магадлан шалгах болсон. Үүний зэрэгцээ бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг боловч бүртгэлгүй аж ахуйн нэгжийг олж илрүүлэхийн тулд харьяа нутаг дэвсгэрийнхээ байшин барилгад нэг бүрчлэн шалгалт хийж

бүртгэлд хамруулах үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлж байна. Мөн 1995,1999 онд дахин бүртгэл хийж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй байгууллагыг бүртгэлээс хассан байна. Иймд одоогийн аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн системийг нэлээн найдвартай гэж үзэж болох юм.

Мөн татвар төлөгч иргэний хувьд 2002 оны 9 сарын 1-нээс эхлэн «татвар төлөгч иргэнд бүртгэлийн дэвтэр олгох систем» хэрэгжиж эхлээд байна. Энэхүү систем хэрэгжиж эхэлснээр экспорт, импорт эрхэлдэг татвар төлөгч иргэн нь ҮТЕГ-т (харьяа татварын алба) «иргэний орлогын дэвтэр»-г авах өргөдөл гаргах ба уг дэвтрийг ГЕГ-т тушаах гаалийн мэдүүлэгт хавсаргах юм. Уг систем нь экспорт, импорт эрхлэх татвар төлөгч иргэн татварын тайлангаа гаргадаггүй зөрчлийг таслан зогсоох зорилгоор хийгдэж байгаа арга хэмжээний нэг юм. Уг дэвтэрт татвар төлөгчийн дугаараас гадна 13 оронтой дэвтрийн дугаараас гадна бүх татварын албаны бүртгэлийн маягтын код (2 орон), татварын алба тус бүрийн код (2 орон), төрсөн он сар өдрийн код (6 орон), хүлээн авсан дугаарын код (3 орон) бичигдэх ба бүх татварын албанд дэвтрийн дугаар давхардахгүй байхаар дугаар олгогдоно.

Юутай ч татвар тэгш шударга байх зарчим нь татвар төлөгч бүр өөрийн орлогод тохирсон хэмжээний татвар төлөхөд оршдог тул татвараа тайлагнаагүй нэг этгээд байлаа ч түүнийг зүгээр өнгөрөөж болохгүй бөгөөд энэхүү үүргээ татварын албаны ажилтан ухамсарлах хэрэгтэй юм.

Мөн бусад арга хэрэглэн татварын тайлан гаргадаггүй татвар төлөгчийн тоог багасгахын тулд ҮТЕГ болон бусад татварын албад татвар төлөгчийн боловсролд чиглэсэн арга хэмжээ (тухайлбал, татварын тайланг хэрхэн гаргах талаар сургалт явуулах, ганцаарчилсан зөвлөгөө өгөх, туслах гэх мэт) хэрэгжүүлэхийн зэрэгцээ зурагт хуудас, зарлалын самбар, мэдээллийн хуудас зэргээр дамжуулан татварын тайланг үнэн зөв гаргах талаар уриалан дуудах мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаа нэн чухал юм.



# **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

*ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТАЛААРХ ХӨНДЛӨНГИЙН  
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ*

### **3.1 Татвар төлөгчийн талаарх мэдээ материалыг цахимжуулахын ач холбогдол, татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн талаар**

- (1) *Төслийн хүрээнд татвар төлөгчийн талаарх мэдээ материалыг цахимжуулах ажлыг дэмжих нь*

Уг системийн хүрээнд хийгдэж буй татварын баримт мэдээллийг цахимжуулах ажлын гол зорилго нь татвар хураалтыг бэхжүүлэхэд орших бөгөөд үүний талаар цэгцлэн авч үзье.

① **Татвар төлөгчийн тайлангийн үнэн зөв байдлыг татварын баримт материалтай тулган шалгах нь**

Системийг ашиглахын нэг гол ач холбогдол нь компьютерийн нэг товчийг ашиглан мэдээллийг тулган шалгах явдал юм. Татварын хяналт шалгалтын үед татварын баримт материалыг өмнө үүсгэгдсэн татвар төлөгчийн талаарх мэдээлэлтэй тулгах болон баримт материалуудыг хооронд нь тулган шалгаснаар татварын тайланд бичигдсэн алдаа зөрүүг илрүүлэх боломжтой болох юм. Мөн ийм боломжийг өргөжүүлснээр хяналт тавих, хязгаарлах үр дүнтэйг дурьдаж болно. Эдгээрээс харахад татварын тайлангийн үнэн зөв байдлыг дээшлүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

② **Татварын хяналт шалгалтын мэдээллийг хангалттай бүрдүүлснээр хяналт шалгалтын ажлын үр бүтээлийг дээшлүүлэх нь**

Татварын хяналт шалгалтын мэдээллийг компьютерийн мэдээлэл болгосноор компьютерийн системээр дамжуулан татварын байцаагч нарыг нэгэн ижил мэдээллээр зэрэг хангах боломжтой болно. Мөн, татварын хяналт шалгалтын мэдээллийн талаарх баримтыг цахим аргаар үйлдэх нь ажлын бүтээмжийг дээшлүүлж, хөнгөвчлөх сайн талтай. Улмаар, хяналт шалгалтын мэдээллийг компьютерийн мэдээлэл болгосноор мэдээлэл ашиглалтын байдал болон мэдээлэл ашиглах хүрээнд тавих хязгаар зэргийг хялбархан хянаж болох юм.

③ **Татварын баримт материалыг хангалттай бүрдүүлснээр татварын бодлогыг тодорхойлох нь**

Тус тусдаа байгаа татварын баримт материалыг нэгтгэн боловсруулснаар татвар төлөлтийн болон ногдуулалтын нөхцөл байдлын талаар нэгдсэн ойлголттой болно. Мөн, статистик мэдээ болгон боловсруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь татварын үйл ажиллагааны чиг хандлагыг тодорхойлох, асуудал дэвшүүлэхэд тустай. Цаашилбал, татварын орлогын төлөвлөгөөг гаргахад үндсэн баримт материал болгон ашиглах боломжтой юм. Энэ мэтчилэн, татвар төлөгчийн гаргадаг тайлан болон татвар төлөлтийн байдлыг компьютерийн мэдээлэл болгож, статистик аргаар боловсруулах нь татварын бодлогыг зүй зохистойгоор тодорхойлоход тус болох юм.

- (2) *Төслийн хүрээнд татвар төлөгчийн талаарх мэдээллээр мэдээллийн сан үүсгэсэн тухай*

① **Татварын тайлангийн мэдээллийг цахимжуулах нь**

Татвар хураалтыг бэхжүүлэхийн тулд авч хэрэгжүүлж буй цахимжуулах үйл ажиллагааны нэгдүгээрт татвар төлөгчийн гаргадаг тайланг компьютерийн мэдээлэл болгох ажлыг дурьдаж болно. Энэ ажлыг гүйцэтгэснээр, татвар төлөлтийн болон хойшлогдсон татварын нөхцөл байдлыг түргэн шуурхай тодорхойлох боломжтой болохоос гадна эдгээрийг статистик аргаар боловсруулж татварын бодлогыг тодорхойлоход ашиглаж болох юм.

Уг төслийн хүрээнд ч гэсэн эхлээд татвар төлөгчийн тайланг мэдээллийн санд оруулна гэж төлөвлөж байсан ч хэдийнээ 2001 онд Азийн хөгжлийн банкны тусламжаар Монголын ҮТЕГ-т татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллийн санг байгуулсан нь 2002 оноос ажиллаж эхлээд байсан юм. Уг төслийн хувьд энэ

системийн эцсийн шатанд технологийн талын зөвлөлгөө өгөв.

② **Гаалийн мэдүүлгийн мэдээллийг цахимжуулах нь**

Гаалийн мэдүүлгийг ГЕГ-т компьютерийн мэдээлэл болгон мэдээллийн санд оруулсан байсан хэдий ч түүнийг УТЕГ-ын татвар хураалтын үйл ажиллагаанд мэдээлэл болгон ашиглах тохиолдол олон бус байжээ. Мөн дор дурьдсанчлан ГЕГ нь 2002 оноос сүлжээгээр дамжин ажиллах шинэ систем байгуулсан ба тэрхүү системийн мэдээллүүд нь өмнөхийг бодвол бусад системд хялбархан ашиглаж болдог болсон.

Уг төслийн хүрээнд систем байгуулахдаа ГЕГ-ын шинэ системээс тогтсон хугацаанд гаалийн мэдүүлгийг авч байх шийдлийг хийв.


③ **Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийг цахимжуулах нь**

Зөвхөн татвар төлөгчийн өөрийн гаргасан тайлангаар зогсохгүй тухайн татвар төлөгчийн санхүү эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт үндэслэл болгоход үнэмшилтэй байх бөгөөд хөндлөнгийн эх үүсвэрт үндэслэн мэдээллийг татварын хяналт шалгалтад ашиглах шаардлагатай юм. Ийм мэдээллийг компьютерийн мэдээлэл болгон боловсруулж, татварын хяналт шалгалтанд үр ашигтайгаар ашигласнаар үнэн зөв бичигдээгүй тайланг илрүүлэн, татвар хураалтыг бэхжүүлэх арга хэмжээг үр дүнтэй болгох ач холбогдолтой.

Уг төслөөр мэдээлэлжүүлэлтийг дэмжихдээ Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санг үүсгэн байгуулахад голлон анхаарч ажиллав.

(3) *Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн талаарх ерөнхий ойлголт*

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн ерөнхий схемийг Зураг.1-д үзүүлэв. Хөндлөнгийн мэдээллийн хувьд ихэнх нь цаасаар цуглардаг байсан. Уг төслөөр эдгээрийн доторх зарим мэдээллийг цахимжуулж, сүлжээгээр дамжуулан ашигладаг болгохоор болов. Бусад мэдээллийн хувьд урьдын адил цаасаар цуглуулж, ашиглаж, хянах бөгөөд ирээдүйд цахимжуулах талаар авч үзэх юм. Мөн, дор дурьдсанчлан НӨАТ-ын падаан, суутган авсан татварын тайлан зэргийн тухайд системийн бүтцэд тусгасан байгаа боловч мэдээллээ цаасаар ашиглах болно.



баримт мэдээлэл болгон ашиглахыг зорив. Цахимжуулсан мэдээлэл нь мэдээлэл тус бүрийг бусадтай нь харьцуулан тулгаж, нэгтгэснээр хяналт шалгалтын ажлыг өндөр хэмжээнд мөн үр бүтээлтэй, түргэн шуурхай явуулах боломжтой болох юм.

② **Клиент сервэр горимтой системийг үүсгэх**

Энэхүү төслөөр клиент сервэр горимтой системийг төлөвлөж байгаа юм. Энэ нь ашиглах гэж байгаа мэдээллээ хэрэглэгч өөрийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн боловсруулж ашиглах боломж олгох юм. Бас, хэрэглэгч талын мэдээлэл ашиглалтын талаарх мэдээ зэрэг клиентээс сервэр рүү мэдээлэл илгээх боломжтой болно.

Мөн, мэдээллийн сангийн менежментийн системээр дор дурьдсанчлан Oracle компанийн Oracle 8 ба 9-г ашигласнаар цаашид мэдээллийн агуулга болон хэмжээг нэмэгдүүлэх болон ашиглалтын аппликэшн-г зохиох шаардлага гарсан тохиолдолд ч хангалттай бэлэн байх зохион байгуулалттай билээ.

③ **Алслагдсан газрууд алсын сүлжээгээр дамжуулан мэдээллийг хамтран эзэмших нь**

Мэдээллийг YTEГ-т төвлөрүүлэн компьютерт оруулах юм. Мэдээллийг алсын сүлжээгээр дамжуулан YTEГ болон татварын албадын хооронд хамтран эзэмшиж болно. Хамтран эзэмших мэдээлэл нь сүлжээгээр дамжин илгээгдэх учраас алслагдсан газруудад ч нэгэн ижил цаг хугацаанд мэдээллийг өөрчлөх боломжтой.

④ **Мэдээлэл ашиглалтын байдлыг мэдэх болон хамгаалалтын арга хэмжээ**

Энэхүү системд агуулагдаж буй мэдээллийн ашиглалтын байдлыг мэдэх боломжтой. Ингэснээр татварын байцаагч нэг бүрийн мэдээлэл ашиглаж байгаа байдлыг хянаж чадахын зэрэгцээ хууль бусаар мэдээлэл ашиглах үйлдлийг цаг алдалгүй илрүүлэх боломж нээгдэх юм.

(4) *Татвар төлөгчийн талаарх бусад баримт мэдээллийг мэдээллийн сангийн хүрээнд ашиглах талаар*

① **Татвар төлөгчийн талаарх мэдээллийн сан**

Монгол Улсын Үндэсний Татварын Ерөнхий Газар нь өөрт ашиглах татвар төлөгч болон татвар төлөлтийн талаарх нийт мэдээллийг багтаах зорилгоор мэдээллийн систем үүсгэн байгуулсан билээ. Энэ нь татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл болон татварын тайлангийн мэдээллээр байгуулсан мэдээллийн сан юм.

Ингэснээр татвар төлөгчийн талаарх мэдээлэлд тавих хяналтыг үр ашигтай бөгөөд зөв зохистой хэрэгжүүлэхийн хамт татварын хяналт шалгалтанд тус нэмэр болгох зорилготой юм.

**а. Системийг ашиглах цар хүрээ**

Системд хамруулах нь татвар төлөгчийн **мэдээллийн бүртгэл болон** тайлантай холбоотой мэдээллүүд юм. Эдгээр мэдээлэлд үндэслэн татварын статистик мэдээллийг ч гаргана. Нийт 19 төрлийн татварыг талаарх мэдээллийг тусгасан байгаа. Системийг YTEГ-ын дотоодод болон нийслэл, аймгийн татварын албад ашигладаг.

**б. Системийн үндсэн бүтэц**

Hardware нь сервэрийг цөм болгон түшиглэсэн сервэр клиент систем юм.

YTEГ болон нийслэл, аймгийн татварын албад хоорондын мэдээллийн холбоо нь цахим шуудан ба мэдээллийг импортлох горимоор явагддаг. Мэдээллийн сангийн менежментийн систем нь SQL бөгөөд Oracle компанийн Oracle 8-аар ажиллана.

Аппликэшн нь жишээлбэл татвар төлөгчийн бүртгэл, татварын төрөл тус бүрээр гаргадаг тайланг боловсруулах, мэдээллийг татварын хяналт шалгалтанд ашиглах

зориулалтаар боловсруулах зэрэг ажил үүргийн ялгаатай нийт 17 программ зохиосон байна.

Мэдээллийг хянах гол түлхүүр нь татвар төлөгч хувь хүний бол регистрийн дугаар, ААНБ-ын хувьд улсын бүртгэлийн дугаар байна. Регистрийн дугаар нь ИБМҮТ-өөс нийт иргэдэд анх төрөхөд нь олгогддог. ААНБ-ын улсын бүртгэлийн дугаарыг ААНБ байгуулагдаад татварын албанд бүртгүүлэхэд олгодог.

#### **в. Системийг үүсгэн байгуулах болон үйл ажиллагааг удирдан явуулах зохион байгуулалт**

Үүсгэн байгуулах ажлыг ҮТЕГ-н холбогдох ажилтнууд өөрсдөө хийсэн ба 2001 оны 8 дугаар сараас 3 сар гаруйн хугацаанд 5 хүний бүрэлдэ хүүнтэй ажиллажээ. Мэдээллийн санг ашиглах ажилтнуудад 3 долоо хоногийн сургалт явуулсан байна.

#### **② Гаалийн мэдээллийн сан**

##### **а. Системийг байгуулсан зорилго, нөхцөл байдал**

Өмнө нь ажиллуулж байсан (Asycuda) системийн үйл ажиллагаа болон байнгын хэвийн ажиллагааг хангах тал дээр хэдийнээ доголдол гарч, улмаар асуудлыг шийдэхийн тулд нэлээд хэмжээний зардал гаргах шаардлагатай болоод байжээ. Иймд шинэ системийг монголын нэгэн вэндэр компаниар хийлгүүлсэн байна.

Системийг нэвтрүүлэхдээ дараах дөрвөн зорилтыг хангахаар төлөвлөжээ.

- Гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулах
- Статистик мэдээний боловсруулалт
- Татварын төрөл зүйлээр ялгасан мэдээллээр мэдээллийн сан үүсгэх
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Эдгээр зорилгыг биелүүлэхийн тулд үр ашигтай бөгөөд сүлжээ байгуулахад хялбар дөхөм байх клиент сервэрийн горимтой систем байгуулахаар болжээ. Уг системийн хүрээнд улсын хилийн гаалиас авахуулаад бүхий л гаалийн боомт, газрыг сүлжээгээр холбохоор төлөвлөж байгаа юм.

Системийг үүсгэн байгуулах болон туршилтийн ажиллагааг 2001 оны 8 дугаар сараас 2002 оны 12 дугаар сар хүртэл хийж дуусгах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд 2003 оноос шинэ систем рүү бүрэн шилжихээр ажиллаж байгаа юм байна.

##### **б. Системийг ашиглах цар хүрээ**

ГЕГ-ын шинэ систем нь үндсэн гурван шатанд хэрэглэгчдийг мэдээллээр хангана. Нэгдүгээрт, ГЕГ, гаалийн боомт зэрэг голдуу байгууллагын дотоодын сүлжээг ашиглах хэрэглэгч, хоёрдугаарт, web application-н хувьд интернэтэд зохих хамгаалалтыг хангасны үндсэн дээр аппликэшн ба мэдээллийн санг ашиглах ГЕГ-ын гадны хэрэглэгч байж болох бөгөөд тодруулбал мэдээлэл оруулах зэрэг ажиллагааг гүйцэтгэх брокерууд, гуравдугаарт интернэтийн жирийн хэрэглэгч буюу төрөл бүрийн мэдээллийг авахаар хандах хүмүүс байж болох юм.

Брокеруудын хувьд гаалийн боомтын албан контор руу холбогдох маягаар системийг ашиглана. Урьд нь брокерийн хийж гүйцэтгэдэг бүрдүүлгийг хүлээж авах цаг нь гаалийн боомтын албан конторын цагийн хуваарьт баригддаг байсан бол энэхүү шинэ системийг нэвтрүүлснээр 24 цагийн турш хүлээж авах боломжтой болох юм.<sup>1</sup>

##### **в. Системийн үндсэн бүтэц (Hardware болон Software-н бүтэц)**

Шинэ систем нь клиент сервэрийн горимоор ажилладаг систем юм. Сервэрийн OS нь Windows 2000 Server юм. ГЕГ-аас гадна нийслэлийн хоёр (төмөр замын, нисэх буудлын) боомт болон БНХАУ, ОХУ-тай хиллэдэг 2 боомт нийт 4 газраас гадна Улаанбаатар хотын гаалийн газрыг сүлжээгээр холбоно.

Мэдээллийн сангийн аппликэшн нь Microsoft компанийн SQL 7.0-г ашиглаж байгаа

<sup>1</sup> Мэдээллийн боловсруулалтыг ажлын цагийн хугацаанд хийнэ

бөгөөд үүнд үндэслэн аппликэшнийг дангаар үүсгэн зохиожээ. Сүлжээний хувьд Улаанбаатар хот дотор шилэн кабель ашиглан холбогдож, хилийн гаальтай хиймэл дагуулын туслалцаатайгаар холбогдоно.<sup>2</sup> Мэдээллийг өөрчлөх давтамж урьд нь өдөрт 1-2 удаа байсныг 15 минут тутамд болгоно.

(5) *Төслийн энэ шатанд системийг үүсгэн байгуулсан ажлын зохион байгуулалтын тухай*

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн системийг голлосон татварын баримт мэдээллийн санг бүрдүүлэх төсөл

① **Системийг үүсгэн байгуулах ажлын зохион байгуулалт, оролцогсдын гүйцэтгэсэн үүрэг**

Системийг үүсгэн байгуулах ажлын зохион байгуулалт, оролцогсдын гүйцэтгэсэн үүргийн талаар авч үзье.

**а. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАИКА)**

Системийг үүсгэн байгуулахад ЖАИКА-гийн гүйцэтгэсэн үүрэг нь

- Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн системийг голлосон татварын баримт мэдээллийн санг бүрдүүлэх төслийн хүрээн дэх технологийн дэмжлэг
- Системийг үүсгэн байгуулахтай холбоотой санхүүгийн дэмжлэг

гэсэн хоёр зүйл дээр төвлөрнө. Эхний зүйлийн хувьд УТЕГ-ын өнөөгийн мэдээлэлжүүлэлтийн нөхцөл байдлыг судалж тогтоосны үндсэн дээр Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн систем ямар байх ёстойг тодорхойлж, төслийн менежментийн арга барил, систем байгуулах нөхцөл байдлыг тодруулан хянах, системийн дизайн, системийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг зэргийг голдуу зөвлөх байр сууринаас үзүүлж ирэв. Хоёр дах зүйлийн тухайд гэвэл, Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн системд шаардлагатай техник төхөөрөмж, программ хангамжийг бүрдүүлэх болон системийг үүсгэн байгуулахад чухал шаардлагатай вэндэр компаниар гүйцэтгүүлэх ажлын хөлсийг гаргах зэрэг санхүүгийн дэмжлэг туслалцааг үзүүлж ирлээ.

**б. Монголын УТЕГ**

Үндэсний Татварын Ерөнхий Газрын гүйцэтгэсэн үүрэг нь

- Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санг үүсгэн байгуулах төслийн менежмент (вэндэр компаниар гүйцэтгүүлэх ажилд тавих хяналт зэрэг)
- ГЕГ болон УТЕГ-ын хооронд мэдээлэл солилцох системийн төслийн менежмент
- Мэдээллийн сангийн дизайн, программ зохиох
- Мэдээллийг бүрдүүлэх
- Хэрэглэгчдийг сургах
- Холбогдох бүхий л баримт бичгийг үйлдэх

зэргээр тодорхойлогдоно.

Төслийн менежментийн тухайд вэндэр компаниар гүйцэтгүүлэх ажлын бэлтгэл шат дамжлагуудыг хангах болон хянах гэх зэргээр системийг үүсгэн байгуулах ажлын зохион байгуулалтыг нийтэд нь хамаарч гүйцэтгэсэн болно.

Нийт дизайнаас гадна голдуу хамгаалалтын хувьд чандлан анхаарах шаардлагатай программыг УТЕГ-н ажлын хэсэг бичсэн болно.

Мэдээллийн санд хамруулах мэдээллийн тухайд бол урьд нь цаасаар цуглардаг байсан мэдээллийг цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэв.

---

<sup>2</sup> Нисэхийн гааль болон ГЕГ-тай нийтийн хэрэглээний холбооны сүлжээгээр дамжуулан холбогдоно.

Хэрэглэгчдийн сургалт, холбогдох бичиг баримт бүрдүүлэх ажлыг системийг үүсгэх ажил дууссаны дараа ҮТЕГ-ын ажлын хэсэг хийж гүйцэтгэв.

#### **в. Бусад**

Системийг үүсгэн байгуулах ажлын хоёр хэсгийг вэндэр компаниар гүйцэтгүүлэв. Үүний нэг нь, Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санг үүсгэн байгуулахад үзүүлэх дэмжлэг болгон программ бичих, нэвтрүүлсэн сервэрийн ажиллах бэлтгэлийг хангах зэрэг, хоёр дах нь ГЕГ болон ҮТЕГ-ын хооронд мэдээлэл солилцох системийн программыг хийж гүйцэтгүүлэв.

#### **② Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн системийг үүсгэн байгуулсан ажлын зохион байгуулалт**

Дээр дурьдсанчлан төслийн менежмент болон программ бичих, систем үүсгэхтэй холбоотой ихэнх ажлыг ҮТЕГ хийж гүйцэтгэв. Мөн, ажлын нэг хэсгийн төслийн менежмент ба программ бичилтийг монголын программ хангамжийн вэндэр компани болох ТТТ компаниар гүйцэтгүүлэв. Энэхүү вэндэр компанийг ЖАИКА-гийн судалгааны багийн хийсэн судалгаагаар технологийн үнэлэлт өгсний үндсэн дээр сонгосон болно.

#### **③ Татвар төлөгчийн мэдээллийн системийг үүсгэн байгуулсан ажлын зохион байгуулалт**

Төслийн менежмент, системийн дизайн, гаалиас илгээгдэх мэдээллийг хүлээн авах хэсгийн программыг ҮТЕГ хийж гүйцэтгэв. Гаалиас мэдээлэл илгээх хэсэг зэргийн тухайд бол ГЕГ-ын системийг үүсгэн байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн монголын программ хангамжийн вэндэр компани болох ЕСМ компаниар гүйцэтгүүлсэн болно.

### **3.2 Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагаа болон бүтэц**

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагаа, бүтцийн талаар авч үзье.

#### *(1) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн гүйцэтгэх үйлдэл*

Уг мэдээллийн сангийн гүйцэтгэх үйлдэл, мэдээллийн агуулга, ашиглалтын талаарх нэгтгэл тайлан, хайх түлхүүр, ашиглах цар хүрээний талаар дор дурдав.

#### **① Гүйцэтгэх үйлдлийн талаарх ерөнхий ойлголт**

##### **а. Татвар төлөгчийн талаарх мэдээлэлтэй тулган шалгах**

Энэхүү мэдээллийн сан нь системийн хүрээнд, хөндлөнгийн этгээдийн эзэмшиж буй мэдээллийг цуглуулан ҮТЕГ-ын хяналтанд байдаг татвар төлөгчдийн талаарх мэдээллүүдтэй тулган шалгана. Ингэснээр мэдээлэл тус бүрийг тухайн татвар төлөгч нэг бүртэй үнэн зөв бөгөөд үр дүнтэйгээр холбож, татвар төлөгчдийн татвар төлөлтийн тухай зөв зүйтэй мэдээлэл авах боломжтой болох юм.

##### **б. Мэдээллийг хайх**

Уг мэдээллийн санд багтсан татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийг хэд хэдэн ангиллаар хайх боломжтой. Төлөөлүүлэн дурьдвал, татвар төлөгч тус бүрээр санхүү, эдийн засгийн үйл ажиллагааных нь хүрээ зэргийг тогтоон тухайн татвар төлөгчтэй холбоотой мэдээллүүдийг цэгцтэйгээр хянах боломжтой юм.

##### **в. Мэдээллийн нэгтгэл**

Мэдээллийг удирдлага болон татварын байцаагч ашиглахад дөхөмтэй болгох үүднээс нэгтгэл гаргана. Нэгтгэлээр, хайх үйлдлийг ашиглан тухайлсан татвар

төлөгч болон бараа материал зэргээр хамаарах мэдээллийг нэгтгэн боловсруулсан үр дүн, санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхойлж чадах мэдээг гаргана.

**г. Мэдээлэл солилцох**

Уг мэдээллийн сан нь гаднаас илгээгдсэн цахим мэдээллийг хүлээн авах, эсвэл өөрт багтаасан мэдээллийг илгээх үйлдлийг хийж гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, гаалийн мэдээ болон татварын албадаас илгээгдэн ирэх мэдээллийг хүлээн авч, татварын албад руу хамаарах татвар төлөгчийн талаарх мэдээллийг нь илгээнэ гэсэн үг юм.

**д. Мэдээллийн ашиглалтыг хянах**

Уг мэдээллийн сангийн мэдээллийг ашиглаж буй байдалд хяналт тавьж мэдээллийн төрөл зүйл тус бүрээр ашиглалтын байдлыг тогтоох боломжтой.

**е. Хамгаалалт**

Системийн OS-с гадна мэдээллийн сангийн log in хяналт тавигдана. Мөн мэдээлэл ашигласан талаар нарийн тодорхой бүртгэл хийгдэхийн зэрэгцээ цахим мэдээг хуулбарлах зэрэг тохиолдолд ч бүртгэгдэх болно. Татварын албадад системийн үйл ажиллагаанд гэмтэл доголдол учрахад үйл ажиллагааг нөхөн сэргээх үйлдэл хийгдэнэ.

**② Мэдээллийн агуулга**

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн системд агуулагдах мэдээллийг хүснэгт 1-д үзүүлэв. Энэхүү мэдээллийн сангийн систем нь хүснэгтэд үзүүлсэн бүх мэдээллийг агуулах бүрэн боломжтой хэдий ч мэдээллийг цуглуулах нөхцөл боломж зэргээс үүдээд НӨАТ-ын падаан, суутган авсан татварын тайлангийн мэдээллийн хувьд цуглуулах, компьютерт оруулах нөхцөл бүрдсэн хойно мэдээллийн санд оруулах юм.

Мэдээллийн нэр	Уг мэдээллийн талаар	цахимжуулсан эсэх
Гаалийн мэдээ	Гаалиар импорт, экспортын гүйлгээ хийсэн этгээдийн мэдүүлэг, холбогдох татвар ногдуулсан талаарх гэх мэт мэдээлэл. Цахим байдлаар илгээгдэнэ.	○
Хөндлөнгийн мэдээлэл цуглуулах хуудас	Татварын албаны байцаагчдын цуглуулсан татвар төлөгчийн талаарх мэдээлэл. ҮТЕГ руу цаасаар ирнэ.	○
Спиртийн мэдээ	Спирт хуваарилсан болон борлуулсан тухай мэдээлэл. ХХААҮЯ ба спирт үйлдвэрлэгч ААНБ-аас цаасаар ирнэ.	○
НӨАТ-ын падаан	Гүйлгээ хийгдэх тоолонд бичигдэх мөнгө төлсөн баримт бөгөөд төлөгдсөн НӨАТ-ыг тооцон бичсэн байна. Цаасаар авахаар төлөвлөж буй.	×
Суутган авсан татварын тайлан	ААНБ нь хувь хүнийг гэрээгээр ажиллуулсан, эсвэл хувь хүнээс бараа материал худалдан авсан тохиолдолд цалин, бараа материалын үнэ болгон төлсөн үнийн дүнгээс суутган авсан татварыг бичих маягт бөгөөд татварын албад дээр цугларна. Цаасаар авахаар төлөвлөж буй.	×

Хүснэгт 1. Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санд агуулагдах мэдээллүүд

**③ Мэдээллийг хайх**

Мэдээллийн санд агуулагдах мэдээллийн талбар (field) тус бүрийн нүдэнд нөхцөл зааж оруулахад тэрхүү нөхцлийн дагуу мэдээллийг хайх боломжтой. Жишээлбэл, тухайлсан татвар төлөгчийн талаарх мэдээлэл шаардлагатай бол уг татвар төлөгчийн дугаарыг зохих нүдэнд шивж оруулснаар хэрэгтэй мэдээллээ авч болно. Мөн, тогтсон нэг хүрээ хязгаарыг нөхцөл болгон мэдээлэл хайх (жишээлбэл, 100 мянган ам.доллараас дээш экспортын гүйлгээ хийгдсэн гаалийн мэдээ) тохиолдолд нэг болон түүнээс олон нөхцөлийг заавал хэрэгцээт мэдээллээ авч



болох юм.

#### ④ Мэдээллийг хайх түлхүүр

##### а. Баримт мэдээллийг ялгах код

Баримт мэдээллийг хянах дугаарыг мэдээлэл тус бүрд олгоно. Энэ дугаарын эхний 2 орон нь мэдээллийн агуулгын төрлийг заана. Дараах 11 орон нь дэс дарааллын дагуу олгогдоно. Баримт мэдээллийг хянахдаа энэ дугаарыг үндэс болгоно.

##### б. Татвар төлөгчийг ялгах код

Татвар төлөгчийн дугаар (регистрийн дугаар, ААНБ-ын улсын бүртгэлийн дугаар) болон татвар төлөгч хувь хүний бүртгэлийн дэвтрийн дугаарыг ялгах код болгоно. Энэхүү код нь мэдээллүүдийг хамаарах татвар төлөгчтэй нь холбон тулгахад ашиглагдана. Гэхдээ татвар төлөгч хувь хүний бүртгэлийн дэвтрийн дугаарын хувьд хангалттай нэвтэрч чадаагүй байгаа тул татвар төлөгчийн дугаарыг тулган шалгах түлхүүр болгон ашиглаж байгаа.

#### ⑤ Мэдээллийг ашиглах цар хүрээ


##### а. Мэдээллийг ашиглах боломжит хугацаа

Мэдээлэл нь мэдээллийн санд орсноос хойш 7 жилийн туршид хадгалагдана. Энэ хугацаа өнгөрөхөд программ ажиллаж мэдээллийн сангаас арчигдана. Мэдээллийг ашиглах цаг нь зарчмын хувьд ажлын цаг дотор багтах болно.

##### б. ҮТЕГ, татварын албанд ашиглаж болох мэдээллүүд

ҮТЕГ дээр бол уг системд агуулагдах бүх мэдээллийг ашиглаж болно. Татварын албад дээр зөвхөн тухайн ТА-д хамаардаг татвар төлөгчийн талаарх мэдээллийг л ашиглах боломжтой.

(2) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн бүтэц  
Системийн бүтцийн ерөнхий схемийг зураг 2-т үзүүлэв.



## Зураг 2. Мэдээллийн сангийн гүйцэтгэх ажиллагааны бүтэц

### ① Системийг ашиглах орчин нөхцөл

#### а. Барилга байгууламж

Энэхүү систем нь ҮТЕГ болон татварын албаны барилга дотор ашиглагдах болно. Толгой серверийг ҮТЕГ-т, ТА-ны серверийг тухайн ТА дээр суурилуулахаас гадна ГЕГ-тай мэдээлэл солилцох зэрэгт ашиглах серверийг ГЕГ дээр суурилуулна.

#### б. Тоног төхөөрөмжийн өрөө

Холбогдох барилга байгууламжид системийн тоног төхөөрөмжийг

ҮТЕГ-т: сервер (тоног төхөөрөмжийн өрөөнд)

клиент компьютер (албан тасалгаанд)

ТА-нд: сервер, клиент компьютер (албан тасалгаанд)

ГЕГ-т: сервер (тоног төхөөрөмжийн өрөөнд)

гэсэн байдлаар суурилуулсан байгаа.

### ② Hardware-н бүтэц

#### а. Сүлжээний бүтэц

Системийн сүлжээний бүтцийг хүснэгт 2-т үзүүлэв.

Сүлжээг хаана ашиглах	Ямар сүлжээ болох
ҮТЕГ-ын барилга дотор	LAN
Татварын албадад	LAN
ҮТЕГ болон ГЕГ-ын хооронд	WAN (олон нийтийн хэрэглээний холбооны шугамаар dial-up хийх)
ҮТЕГ болон татварын албад хооронд	WAN (олон нийтийн хэрэглээний холбооны шугамаар dial-up хийх)

### Хүснэгт 2. Системийн сүлжээний бүтэц

#### б. Серверийн бүтэц

Системийн хүрээнд 3 төрлийн сервер, тодруулбал ҮТЕГ-т суурилагдах сервер, татварын албадад суурилагдах сервер, мөн ГЕГ-т суурилагдах сервер ажиллана. ҮТЕГ-т суурилуулах сервер нь энэхүү системээр дамжуулан ашиглагдах бүх мэдээллийг агуулахын хамт системтэй холбоотой бүхий л программ зэргийг өөртөө багтаана. Татварын албаны сервер нь тухайн албаны татварын хяналт шалгалтанд шаардагдах хөндлөнгийн мэдээлэл, зохих программыг агуулна. ГЕГ-ын сервер нь гаалийн мэдүүлгийн системээс ҮТЕГ руу илгээх мэдээлэл болон тэдгээрийг экспорт хийхэд шаардлагатай программыг агуулна.

#### в. Клиентийн бүтэц

ҮТЕГ-ын хувьд мэдээллийг оруулах зориулалттай компьютер болон татварын хяналт шалгалтын ажилд хэрэглэгдэх клиент компьютер байна. Татварын албад бол хяналт шалгалтын ажилд хэрэглэгдэх клиент компьютер байна.

### ③ Software (программ хангамж)-н бүтэц

#### а. OS-н бүтэц

Серверүүд нь MS-Windows 2000 Server-г ашиглана. Клиент нь MS-Windows 98-с хойшхийг ашиглана.

#### б. Мэдээллийн сангийн менежментийн системийн (DBMS) бүтэц, ерөнхий ойлголт

Уг системийн хувьд мэдээллийн сангийн менежментийн систем (DBMS) нь Oracle

9.1 байна. Мэдээллийн сангийн хяналт хязгаарлалт нь Oracle-н Application Developer's kit –ээр үүсгэгдсэн программаар ажиллана.

**в. Бусад аппликэшний тухай**

ГЕГ-аас ҮТЕГ руу мэдээлэл илгээх, ҮТЕГ болон татварын албадын хооронд мэдээлэл илгээхдээ **ftp** –г ашиглана. Мөн вирусээс сэргийлэхийн тулд түүнийг хайж илрүүлэх вакцин софтыг нэвтрүүлсэн.

**④ Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн бүтэц**

Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сан нь татвар төлөгчийн мэдээллийн table, татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн table, баримт мэдээллийг хянах table зэргээс бүрдэнэ.

**3.3 Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдах, ажиллуулах**

(1) *Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан явуулах*

**① Мэдээллийн сангийн системийн үйл ажиллагааг удирдах**

Мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдах, байнгын хэвийн байдлыг хангах ажлыг ҮТЕГ хийж гүйцэтгэнэ. Мэдээллийн агуулгын байнгын хэвийн байдлыг хангах ажлыг ч ҮТЕГ гүйцэтгэх ба татварын албадад хамаатай мэдээллийг ҮТЕГ-аас албад руу илгээх замаар татварын албанд байгаа мэдээллийн байнгын хэвийн байдлыг хангана. Мэдээллийн нөөц хадгалалт (back-up), нөхөн сэргээх (recovery) арга хэмжээг ч ҮТЕГ дээр авч хэрэгжүүлнэ.

**② Системийн үйл ажиллагаа**

Мэдээллийн сангийн зориулалтаар ашиглах толгой сервэрийг ҮТЕГ дээр ажиллуулж, татварын албаны сервэрийг тухайн албаны систем хариуцсан ажилтан хариуцаж ажиллуулна.

Системийг ашиглахтай холбоотой бүртгэл тэмдэглэгээ зэрэгт тавих хяналтыг сервэрийн ажиллагааг хариуцсан ажилтан хийнэ.

**③ Мэдээллийн байнгын хэвийн байдлыг хангах**

**а. Бүртгэл тэмдэглэгээ**

Мэдээллийн сангийн ашиглалтын талаарх бүртгэл тэмдэглэгээг ҮТЕГ хийж гүйцэтгэнэ. Администратор, оператор зэрэг хэрэглэгчийн бүртгэл тэмдэглэгээг ҮТЕГ хийнэ.

**б. Мэдээллийг оруулах**

Энэхүү системд ашиглагдах мэдээллийн дотроос цаасаар цугларах мэдээллийг (спиртийн мэдээ, хөндлөнгийн мэдээлэл цуглуулах хуудас, ирээдүйд НӨАТ-ын падаан, суутган авсан татварын тайлан) ҮТЕГ дээр компьютерт шивж оруулна. ҮТЕГ дээр энэ зориулалтын компьютерийг байрлуулж, оператор шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

**в. Мэдээллийг өөрчлөх, устгах**


Мэдээллийн сангийн мэдээллийг өөрчлөх, засварлах шаардлагатай тохиолдолд тэрхүү өөрчлөх, устгах ажлыг ҮТЕГ дээр хийж гүйцэтгэнэ. Мөн мэдээллийн санд оруулснаас хойш 7 жил болсон мэдээллийг устгах ажлыг ч мөн адил ҮТЕГ дээр хийж гүйцэтгэнэ. Эдгээр ажлыг администратор биечлэн хийнэ.

**④ Мэдээллийг тулган шалгах**

Системийн хүрээнд мэдээллийн байнгын хэвийн байдлыг хангах үүднээс татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл болон мэдээллийн сангийн мэдээллийг хооронд

нь тулган шалгана.

Юуны өмнө, оруулсан мэдээлэл болон гаднаас хүлээн авсан мэдээллийг татвар төлөгчийн мэдээлэлтэй тулган шалгаж, мэдээллийн санд оруулна. (Зураг 3) Энэ ажлыг УТЕГ дээр хийж гүйцэтгэнэ. Тулган шалгахдаа татвар төлөгчийн дугаарыг түлхүүр болгоно.



Зураг 3. Мэдээллийг оруулах үед тулган шалгах ерөнхий урсгал

Мөн, татвар төлөгчийн татварын албаны харъяаллын өөрчлөлтийг магадлан шалгахдаа шаардлагатай мэдээллийг тулган шалгах ба энэ үйлдлийг ч УТЕГ дээр хийж гүйцэтгэнэ. Мэдээллийг тулган шалгах ажил нь администраторын үүрэг юм.

- ⑤ **Мэдээллийн нөөц хадгалалт (back-up), системийг нөхөн сэргээх (recovery)**  
УТЕГ нь мэдээллийн нөөц хадгалалтыг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэнэ. Мэдээлэл эвдэрч гэмтсэн, эсвэл систем эвдэрч доголдсон тохиолдолд татварын албаны серверээс өгсүүлээд бүгдийг нь УТЕГ дээр нөхөн сэргээнэ.

⑥ **Мэдээлэл солилцох**

**а. УТЕГ болон татварын албадын хооронд**

Мэдээллийн санд шинэ мэдээлэл орох (мөн мэдээллийг өөрчлөх), татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөний улмаас харьяалагдах татварын алба өөрчлөгдөх тохиолдолд УТЕГ-аас холбогдох татварын албад руу мэдээллийг илгээнэ.

Татварын албаны мэдээлэл ашиглалтын бүртгэл нь эхлээд татварын албаны серверт орсны дараа УТЕГ руу тогтмол хугацаанд илгээгдэнэ.

УТЕГ болон татварын албадын хооронд мэдээлэл солилцохдоо УТЕГ-ын серверт байгаа татварын албадын фолдероор дамжуулна. Илгээх мэдээллийг агуулж буй файлыг илгээгч нь зохих фолдерт хийж, хүлээн авч буй тал нь түүнийг хуулж авах маягаар мэдээлэл солилцоно. Мэдээлэл солилцох файл нь MS-Access горимтой байна.

**б. УТЕГ болон ГЕГ-ын хооронд**

Гаалийн мэдээ нь ГЕГ-аас УТЕГ руу илгээгдэх ба ирсэн мэдээллийг УТЕГ мэдээллийн сандаа авна. УТЕГ-ын талд мэдээлэл солилцох зориулалтаар үүсгэсэн фолдерт ГЕГ мэдээллээ хийх ба УТЕГ нь мэдээллийг нягталж, татвар төлөгчийн мэдээлэлтэй тулган шалгасны эцэст мэдээллийн сандаа авна.


- Системийн хувьд ҮТЕГ-ын серверт ГЕГ-аас WAN-аар дамжуулан log on хийх юм.  
 (2) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн санг ажиллуулах

① **Мэдээллийн санг ажиллуулах меню**

Системд

- Баримт үүсгэх (мэдээлэл оруулах)
- Баримт өөрчлөх
- Мэдээллийн жагсаалт гаргах
- Нэгтгэл гаргах
- Хянах меню

зэрэг багтана.



**Зураг 4. Системийн меню-г схемээр үзүүлсэн байдал**

**а. Баримт үүсгэх (мэдээлэл оруулах)**

Энэ нь цаасаар цугларсан мэдээллийг ҮТЕГ дээр төвлөрүүлэн компьютерт шивж оруулахад зориулсан меню юм. Энэ мөнүгээр спирт хуваарилалт, борлуулалтын мэдээ, хөндлөнгийн мэдээллийн хуудас, НӨАТ-ын падаан, суутган авсан тайланг боловсруулна.<sup>3</sup>

**б. Баримт өөрчлөх**

Нэгэнтээ оруулсан мэдээллийг өөрчлөн засварлах шаардлагатай тохиолдолд энэ мөнүг ашиглана. Энэ мөнүг мэдээллийн санд багтсан бүхий л баримт мэдээллийн өөрчлөлтийн үед ашиглана.

**в. Мэдээллийн жагсаалт гаргах**

<sup>3</sup> НӨАТ-ын падаан, суутган авсан татварын тайлангийн хувьд системийг ажиллуулж эхлэх үед (2003 оны 1 дүгээр сар) системд агуулагдахгүй бөгөөд цуглуулах орчин нөхцөл бүрдсэн үед системд авч эхэлнэ.

Мэдээллийн санд багтаж буй мэдээллүүдийн нарийвчилсан агуулгыг дэлгэцэнд гаргаж, шаардлагатай бол тухайлан заасан нөхцлийн дагуу хайлт хийхэд энэ менюг ашиглана. Жишээлбэл, зураг 5-д гаалийн мэдээг дэлгэцэнд гаргасан байна. Уг менюний дэлгэцэнд гаргах функцийг ашигласнаар мэдээллийг дэлгэцэнд дуудаж гарган, жишээлбэл татвар төлөгчийн дугаарыг түлхүүр болгон хайлт хийх бол дугаарыг оруулахад холбоотой бүх мэдээллийг нэг дор харах боломжтой. Хайлтын функц нь дэлгэцэнд гарах бүх мэдээллийн хувьд заасан нөхцлийн дагуу хайлт хийн ажиллах боломжтой юм.

ГААЛИЙН МЭДЭЭНИЙ ЖАГСГАЛТ

БТД	Мэдүүлэгч	Мэдүүлэгч №	Огноо	ТТД	Нэр	Харуулагч	Нэгж	Дугаар
21000006609	Импорт	004003881A	2002.10.04	2328727				21/1216
21000006670	Экспорт	004003882E	2002.10.05	2690954				21/1575
21000006671	Импорт	004003884C	2002.10.05	2383181				21/1088
21000006672	Импорт	004003885C	2002.10.05	2593181				21/1088
21000006673	Импорт	004003886C	2002.10.05	2588587	АССО ХХК			21/1127
21000006674	Импорт	004003887C	2002.10.07	2593181	Юнайтед Аппарел Мэнгол ХХК			21/1088
21000006675	Импорт	004003888C	2002.10.07	2593181	Юнайтед Аппарел Мэнгол ХХК			21/1088
21000006676	Экспорт	004003890E	2002.10.07	2092971	Дөрвөн уул ХК			24/207
21000006677	Экспорт	004003891E	2002.10.07	2382715	Дундговь Мэнгол			21/823
21000006678	Импорт	004003892C	2002.10.07	2092971	Бүтээн Үйлэ ХК			29/29


  

Им код	Барааны нэр	Хэмжээ нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Валютын төрөл, ханш	Нийт үнэ / хөг /
2.00	Сүлжмэл давуу 56°= 2182,07 79°=2119,11	м2	7327.54	1.17	Америк доллар	1117 9564158.12
2.00	Сүлжмэл давуу 62°= 3149,84 78°=2536,81	м2	958.598	1.59	Америк доллар	1117 17764929.85
2.00	Сүлжмэл давуу 78°= 846,37 60°=1226,58	м2	3548.14	1.46	Америк доллар	1117 5788718.46
2.00	Сүлжмэл давуу 60°	м2	3942.01	1.05	Америк доллар	1117 4822805.03
2.00	Сүлжмэл давуу 72°= 583,59 60°=1541	м2	3415.75	0.85	Америк доллар	1117 3251248.73

Зураг 5. Гаалийн мэдээг дэлгэцэнд үзүүлсэн байдал

Мэдээллийг дэлгэцэнд дуудаж гаргасан болон хайлт хийсэн үр дүнг татварын байцаагчийн хэрэгцээнд зориулан хэвлэн гаргах шаардлагатай бөгөөд үүнийг зураг 6-д үзүүлэв. Мэдээллийг хэвлэн гаргахдаа тэрхүү мэдээллийг ашиглах татварын байцаагчийн харъяалагдах татварын албаны код, нэр, байцаагчийн код, нэрийг оруулж байж хэвлэх үйлдэл хийгдэнэ.<sup>4</sup>

<sup>4</sup> Татварын албаны болон байцаагчийн кодыг оруулахад тус бүрийн нэр нь системээс автоматаар гарч ирнэ.



**Зураг 6. Мэдээллийг хэвлэн гаргах байдлыг үзүүлэв**

**г. Нэгтгэл гаргах**


Энэ нь системд агуулагдах мэдээлэл болон түүний ашиглалтын байдлыг үзүүлэх меню юм.

Мэдээллийн хувьд уг менюг ашигласнаар мэдээллийн төрөл зүйл тус бүрээр хэдэн мэдээлэл байгаа, татварын албадад хэдий хэр хэмжээний мэдээлэл байгаа зэргийг мэдэх боломжтой. Мэдээлэл ашиглалтын байдлын хувьд мэдээлэл бүр ямар хэмжээнд ашиглагдаж байгаа, татварын байцаагчид мэдээллийг ямар хэмжээнд ашиглаж байгаа зэргийг дэлгэцэнд үзүүлж шаардлагатай бол хэвлэн гаргах боомжтой.

**д. Хянах меню**

Хянах менюд импортлох, экспортлох зэрэг мэдээллийг оруулж гаргах функц болон мэдээллийг устгах, хэрэглэгчдийг хянах зэрэг функц багтана.

Импортох функц нь, ГЕГ-аас болон татварын албадаас ҮТЕГ руу илгээгдэх мэдээллийг мэдээллийн санд хүлээн авч оруулах үед ажиллана. Зураг 7-д ГЕГ-аас мэдээлэл импортолж авахад гарах дэлгэцийг үзүүлэв. Импортын үед импортолж байгаа файл болон тэрхүү файльтай холбоотой мэдээллийг дэлгэцэнд гаргах ба энэ нь импортлох файлыг сонгон, үйлдлийг хийх боломж олгоно.



**Зураг 7. ГЕГ-аас мэдээлэл импортлоход гарах дэлгэц**

Ашиглалтын бүртгэл тэмдэглэгээг хянах, мэдээллийг нөөцлөн хуулж хадгалах, шаардлагатай мэдээллийг устгах, систем ба мэдээллийн санг буцаан сэргээх зэрэг бусад функцууд энэ хянах менюд байдаг.

**② Мэдээллийн санг ажиллуулах ажилтан**

**а. Администратор**

Администратор нь дээр дурьдсан хянах меню дээр голчлон ажиллана. Мөн, мэдээллийг өөрчлөх, хайх, нэгтгэл гаргах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**б. Оператор**

Оператор нь мэдээллийг хайх, нэгтгэл гаргах дээр голчлон ажиллана. УТЕГ-ын операторын хувьд мэдээлэл шивж оруулах, мэдээллийг өөрчлөх ажлыг ч хийж гүйцэтгэнэ.

**(3) Хамгаалалтын тухай**

**① Мэдээллийн байнгын хэвийн байдлыг хангахад авч хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээ**

Системийн болон мэдээллийн нөөц хадгалалтыг (back up) тогтмол хийснээр гэнэтийн нөхцөл байдал үүсэхэд бэлтгэлтэй байж чадна. Мөн, системд UPS (цахилгааны доголдоос сэргийлэх цахилгаан эх үүсвэр) –г байнгын залгах нь цахилгаан тасарсан тохиолдолд ч мэдээллийг хадгалан үлдээх арга хэмжээг цаг алдалгүй авах боломж олгоно.

Цаашлаад мэдээллийн нөөц хадгалалтын зориулалтын сервер (back-up server) ажиллуулах нь УТЕГ-т байрлах толгой серверт гэмтэл доголдол гарсан тохиолдолд түүнийг орлуулах ач холбогдолтой.

**② Гаднаас нэвтрэх болон хууль бус үйлдэлтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээ**



Энэхүү системийн гол цөм болох YTEГ-н толгой сервэрийг бат бэх хамгаалалт (цоож түгжээ сайтай) бүхий өрөөнд суурилуулах нь хууль бусаар гаднаас нэвтрэх үйлдлээс сэргийлэх юм. Системийн компьютер төхөөрөмж байрлах өрөөнд орж гарах хүмүүсийг бүртгэн тэмдэглэх нь гаднаас нэвтрэх үйлдлийг өдөр тутмын түвшинд хянан шалгах боломжтой болгоно.

Систем болон мэдээллийн сангийн системд тухайлсан бүртгэл тэмдэглэгээ, нууц үгийг суулгаж өгөх нь хууль бусаар ашиглах үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ болно. Бас, мэдээллийн сангийн системийн нэг функц болгон мэдээлэл ашиглалтын байдлыг бүртгэх ба үүнд тулгуурлан мэдээлэлд хяналт тавьж чадах юм. Улмаар систем лог (system log)-г тогтмол хянаж мэдээллийг зүй бусаар хуулбарлан хэрэглэх үйлдлээс сэргийлнэ.

Үүнээс гадна, системийн ашиглалтын явцад аюулгүй байдлыг хангах үүднээс зарчмын хувьд гадны сүлжээ рүү холбогдохгүй байх нь зүйтэй.

③ **Эвдрэл доголдол гарсан үед авах арга хэмжээ**

Эвдрэл доголдол гарах гэх мэт шаардлагатай тохиолдолд YTEГ-ын систем хариуцсан ажилтанд мэдэгдэж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зохион байгуулагдсан.

④ **Мэдээллийг ашиглах тогтолцоог бүрдүүлэх**

Мэдээллийн хяналт хамгаалалтын журмыг гаргаж, түүний дагуу системийг ашигласнаар хамгаалалтын хэм хэмжээг хангана. Мөн системийн ашиглалтыг төрийн албан хаагчийн нууцыг хадгалах үүргийн талаарх дүрэм журамтай уялдуулан холбож өгснөөр хамгаалалтын арга хэмжээг тогтолцооны хувьд шийдвэрлэх боломжтой болох юм.

(4) *Хэрэглэгчдийг сургах*

Уг системийн хэрэглэгч нь татварын байцаагч байх боловч яг бодитоор мэдээллийн санг ажиллуулах нь YTEГ ба татварын албаны эдийн засагч нар юм. YTEГ дээр мэдээллийн санг ажиллуулах ажилтнуудад зориулж сургалт зохион байгуулсан. Татварын байцаагч нарын хувьд ЖАИКА-гийн төслийн судалгааны багаас зохион байгуулсан технологи дамжуулах семинар зэргээр дамжуулан татварын хяналт шалгалтын үед системийг хэрхэн ашиглах, түүний үр ашиг зэргийн талаар сургалт зохион явуулав.

(5) *Системийн холбогдох баримт бичгийг үйлдэх*

Уг системийн хүрээнд бүрдүүлэн үйлдэх бичиг баримтыг ерөнхийд нь 2 хувааж үзнэ. Үүний нэг нь мэдээллийн сангийн программтай холбоотой дизайн, кодын жагсаалт бөгөөд нөгөө нь ажиллуулах заавар зэрэг болно. Дизайн, кодын жагсаалтыг YTEГ дээр хадгална. Программд засвар өөрчлөлт оруулах зэргээр системийг өөрчлөх тохиолдол тухай бүрд системийн холбогдох баримт бичигт тэрхүү өөрчлөлтийг тусгаж, хадгална.

Ажиллуулах заавар нь YTEГ-ын сервэрийн үйл ажиллагааг удирдах талаар голлон бичсэн системийн үйл ажиллагааг удирдах заавар болон операторын хийх ажлын талаар бичсэн хэрэглэгчийн заавар гэж хоёр янз байна. Системд засвар өөрчлөлт орсноос үүдэн үйл ажиллагааны удирдлага өөрчлөгдөх тохиолдолд YTEГ-т зааврыг өөрчлөн засварлаж, холбогдох ажилтнуудад тараана.

### 3.4 Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) систем

Уг төслийн хүрээнд татвар төлөгчийн талаарх YTEГ-ын мэдээллийг ГЕГ-т өгөх системийг үүсгэн байгуулах ажлыг ч хийж зорилт тавьсан билээ. Тэрхүү системийг үүсгэн байгуулсан талаар авч үзье.

(1) *Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) системийн гүйцэтгэх үйл*

#### *ажиллагаа*

Уг төслийн хүрээнд ҮТЕГ-ын системийн доторх татвар төлөгчийн талаарх мэдээллийг ГЕГ руу илгээх системийг үүсгэн байгуулах ажлыг хийж гүйцэтгэв. Илгээх мэдээлэл нь нийт татвар төлөгч хувь хүн, ААНБ-ын талаарх мэдээлэл байх юм.

ГЕГ нь татвар төлөгчийн талаарх мэдээллээр байгууллагын дотооддоо мэдээллийн сан байгуулж тэрхүү сан руу хандангаа гаалийн мэдүүлгийг мэдээлэлтэй шууд тулган шалгах боломжийг хангах шаардлага тавьсан юм. Иймд мэдээллийг илгээх горимын хувьд систем ажиллаж эхлэх эхэн үед ҮТЕГ-ын татвар төлөгчийн талаарх бүх мэдээллийг (мэдээллийн агуулгын талаар хоёр тал харилцан ярьж тохирсон болно) илгээх ба шинэ мэдээ орох, мэдээлэл өөрчлөгдөх, хасагдах тохиолдолд тухай бүрт нь өөрчлөлтүүдийг тусгана.

#### *(2) Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) системийн үйл ажиллагааг удирдах*

Системийн ерөнхий схемийг Зураг 2-т үзүүлэв. ҮТЕГ-ын татвар төлөгчийн талаарх мэдээллийн сангаас тогтмол хугацаанд мэдээлэл солилцох файлыг үүсгэн, түүнийгээ мэдээлэл солилцох зориулалтын фолдерт хийнэ. Үүний дараа ГЕГ-аас ҮТЕГ-ын сервер рүү dial-up-аар холбогдон, файлыг хуулбарлан авч хэрэглэнэ.

### **3.5 Цаашид татвар төлөгчийн талаарх баримт мэдээллийг цахимжуулахтай холбогдуулан цаашид шийдвэрлэвэл зохих асуудал**

#### *(1) Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сангийн хувьд*

Үүсгэн байгуулсан систем нь мэдээлэл тус бүрээр хайлт хийх тал дээр уян хатан боловч нэг мэдээллээс нөгөө мэдээллийн хооронд хайлт хийх функцийг шийдээгүй юм. Ирээдүйд татварын хяналт шалгалтанд системийг ашиглах явдал улам гүн гүнзгий нэвтэрсэн тохиолдолд мэдээлэл тус бүрийн хооронд «хөндлөн чиглэлийн» хайлт хийх шаардлага гарч болох юм.

Одоогийн байдлаар ерөнхий 5 төрлийн мэдээллийг агуулж байгаа хэдий ч цаасаар авах мэдээллүүдийг цаашид энэ системийн хүрээнд ашиглах хэрэгтэй болвол цахимжуулах шаардлагатай болно.

Ирээдүйд цаасан мэдээллийг цахимжуулах ажлыг үр ашигтай хийснээр одоо байгаа системийн мэдээллийн агуулга, хэмжээ өргөжин нэмэгдэнэ. Жишээлбэл, хөндлөнгийн мэдээлэл цуглуулах хуудас шиг татварын байцаагчийн үйлдэх мэдээллийн хувьд эхнээс нь компьютерийг ашиглах, эсвэл том ААНБ-аас ирэх борлуулалт талын НӨАТ-ын падааны хувьд цахим байдлаар авах зэрэг байж болно.

#### *(2) Татвар төлөгчийн талаарх мэдээллийг өгөх (илгээх) системийн хувьд*

Татвар төлөгчийн талаарх ҮТЕГ-ын мэдээллийг ГЕГ руу илгээх ба энэхүү мэдээллийг гаалийн ажилд үр дүнтэй ашиглахын тулд гаалийн мэдүүлгийн системд тэдгээр мэдээллийг тусгах засвар өөрчлөлт хийх шаардлагатай. Мөн хяналт шалгалтанд ашиглахын тулд ч гаалийн мэдээг ҮТЕГ-аас илгээгдэн ирэх татвар төлөгчийн талаарх мэдээлэлтэй тулган шалгах системийг үүсгэх байгуулах шаардлагатай.

#### *(3) Ирээдүйд татвар төлөгчийн талаарх мэдээллийн сангийн хувьд*

Өнөөгийн байдлаар ҮТЕГ нь татвар төлөгчийн талаарх мэдээллийн сан болон татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сантай байгаа билээ. Хяналт шалгалтын ажлын үүднээс авч үзэхэд эдгээр мэдээллийн санд агуулагдаж буй мэдээллүүдийг хооронд нь уялдуулан нэгтгэн ашиглаж болох орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Ирээдүйд системийг өргөжүүлэх ажлыг хэрэгжүүлэх шатанд энэ талаар авч үзэж судлах нь зүйтэй. Ер нь татвар төлөгчдийн талаарх мэдээлэл нь маш их чанд нууцлалтай байх ёстой тул түүнийг хэн ашиглах, ямар ажил үүрэгт ашиглах вэ гэдэг хүрээ хязгаарыг тогтолцооны хувьд тодорхойлж өгөх гэх мэтээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.